



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БА ТАТВАР

Төрийн бус байгууллагын хөтөч

Улаанбаатар хот
2004 он

DDC
336.207
T-594

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб хуудас: <http://www.soros.org.mn>

<http://www.forum.mn>

© МННХ, 2004

ISBN: 99929-0-331-7

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл МННХ-ийн хаягаар
хандаж зохих зөвшөөрөл авна уу.

“ADMON” компанид хэвлэв.

Утас: 329253



ИРГЭН ТАНЫГ ХӨТЛӨХИЙН УЧИР

Нээлттэй Нийгэм Форумаас бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой сэдвүүдээр иргэдэд зориулсан цуврал гарын авлага боловсруулан гаргаж байгаа билээ. Энэхүү цуврал номын нэг болох “Төрийн бус байгууллага ба татвар” гарын авлагыг Танд өргөн барьж байна.

Энэхүү гарын авлага нь төрийн бус байгууллагатай ямар нэг байдлаар холбоотой ажилладаг иргэн Танд татвар, татвартай холбоотой зайлшгүй мэдээллийг иж бүрнээр нь энгийн, ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр хүргэхийг зорьсон юм. Гарын авлагаас төрийн бус байгууллага, ТББ-д ажилладаг иргэд хуулийн дагуу ямар төрлийн татвар төлөх, аль татвараас чөлөөлөгдөх, хөнгөлүүлэх, татвараа хэрхэн тайлагнах, татвартай холбоотой маргаантай асуудал гарвал хаанаас зөвлөгөө авч болох зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг тодорхой жишээн дээр авч үзэж болно. Түүнчлэн хуулийн нэр томъёоны тайлбартай танилцах боломжийг бүрдүүлэхийг хичээсэн нь уншигч Танд тустай, ач холбогдолтой байх болно гэдэгт итгэж байна. Энэхүү сэдвээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаач, оюутан сурагч, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид зэрэг тухайн сэдвийг сонирхсон хэн бүхэн уг номыг ашиглах бололцоотой юм.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэхүү гарын авлагыг Таны гарт хүргэх бололцоо олгосон Г. Ундрал ахлагчтай Ардчиллын Боловсрол Төвийн хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

Энэхүү гарын авлагын чанар, агуулгатай холбогдсон санал хүсэлтийг osf@soros.org.mn хаягаар бид хүлээн авах болно.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форум
Гүйцэтгэх захирал



Гарчиг

Өмнөх үг	4
1 дүгээр бүлэг. ТББ ба татвар	7
2 дугаар бүлэг. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар	13
3 дугаар бүлэг. Хүн амын орлогын албан татвар	25
4 дүгээр бүлэг. Нэмэгдсэн өртгийн албан татвар	37
5 дугаар бүлэг. Гаалийн албан татвар	51
6 дугаар бүлэг. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	55
7 дугаар бүлэг. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	61
8 дугаар бүлэг. Бууны албан татвар	65
9 дүгээр бүлэг. Төлбөр, хураамж	69
10 дугаар бүлэг. ТББ-ын татвартай холбоотой нийтлэг асуултууд	77
11 дүгээр бүлэг. ТББ-ын татварын чиглэлээр гарч буй асуудал, мэдээлэл авах эх сурвалжууд	97
Хавсралт:	103
1. Нэр томъёоны тайлбар	104
2. Татвар төлөгчийн бүртгэл ба татварын маягтууд	114
3. Ашигласан материал	127
4. Гарын авлага боловсруулагчидтай харилцах хаяг	128

ӨМНӨХ ҮГ

Ардчиллын Боловсрол Төв (АБТ) нь байгуулагдсан үеэсээ Монголын төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх ажлыг өөрийн үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл болгон энэ талаар тодорхой зорилгот арга хэмжээнүүд (сургалт, хурал зөвлөлгөөн, судалгаа, зөвлөгөө, он-лайн мэдээллийн үйлчилгээ, ТББ-уудын сүлжээ уулзалт, хэвлэн нийтлэл, г.м.)-ийг хэрэгжүүлсээр ирсэн юм.

Дээрхи үйл ажиллагааны хүрээнд ТББ-уудын зүгээс байнга тавигддаг болон тулгамддаг асуудлуудын нэг нь татвар юм. ТББ-уудын үйл ажиллагааны үр дүн болоод тогтвортой байдал нь татварын тогтолцооноос ихээхэн хамааралтай байдаг. Монгол улсад татварын хууль эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж тогтсон ба түүнийг хэрэгжүүлэх орчин нөхцөл зохих түвшинд хүрсэн. Татвар төлөгчид татвар төлөх нь зайлшгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч татвар төлөлт төдийлөн хангалттай биш түвшинд байгаа нь нийгэм дэх шилжилтийн үйл явц, хуулиа сахих дэг журам бүрэн төлөвшөөгүй, татварын хуулийг тэр бүр төдийлөн сайн мэдэхгүй байгаа явдлуудаас харагдаж байна.

Ингээд энэ хэрэгцээ шаардлагыг нь хангахын тулд татварын асуудлыг нарийвчлан судалж ТББ-ууддаа дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголт өгөх юмсан гэсэн мөрөөдөлд автагдан явж байтал Нээлттэй нийгэм форумаас “Төрийн бус байгууллага ба татвар” сэдэвт гарын авлага боловсруулах тендер зарлаж, түүнд нь манай байгууллага шалгаран уг номыг боловсруулах ажилд орсон билээ.

“Төрийн бус байгууллага ба татвар” гарын авлагыг боловсруулан бичихдээ ТББ-уудын амьдралд гарч байгаа алдаа оноо, зөрчил дутагдал болон төрийн бус байгууллагуудын удирдлага, хамт олны сонирхсон асуудлуудыг судалсны үндсэн дээр мөрдөж байгаа хууль, түүнийг хэрэгжүүлэх аргачлал, журам, зааврыг нэг мөр зөв ойлгон өдөр тутмын ажил албандаа хэрэглэх, иргэдийн татварын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх үндсэн зорилгыг тавьж ажиллалаа. Ардчиллын Боловсрол Төв нь уг гарын авлагыг Нийслэлийн татварын газрын (НТГ) мэргэжилтнүүдтэй баг болж хамтран боловсруулахдаа энгийн, ойлгомжтой хэлбэрээр, холбогдох жишээ бодлого, тайлбар тодруулга оруулахыг хичээсэн болно.

Нийгмийн сайн сайхны төлөө эвлэлдэн нэгдэж төрийн бус байгууллага байгуулан ажиллаж байгаа болон тэдний үйлчилгээг хүлээн авч байгаа иргэдийн татварын хууль эрх зүйн орчныг ойлгон мэдэрч үйл ажиллагаандаа зөв зүйгэй хэрэглэхэд төрийн бус байгууллагын хөтөч болох энэхүү номыг эрхэм уншигч танд эвлүүлэн толилуулж байна. Хууль тогтоомж байнга шинэчлэгдэж, өөрчлөгдөж байдаг тул тухайн гарын авлагад орсон мэдээлэл 2004 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар үйлчилж байсан хууль тогтоомжуудыг мөрдлөг болгосныг анхааралдаа авна уу.

Таны төлсөн татвар улс орны хөгжлийн үндэс билээ.

“Төрийн бус байгууллага ба татвар” гарын авлагыг зохиогчид:


Г. Ундрал
АБТ-ийн захирал

А. Ёрбáйáýё
ААО-ééí çí ðéðóóéáá+

Хянан тохиолдуулсан: Д. Батжаргал
Б. Мөнхсоёл

Я. Аюушжав
НТГ-ын Хяналт, шалгалтын
хэлтсийн дарга

Ц. Цэцэгням
НТГ-ын Хяналт,
шалгалтын байцаагч



I бүлэг

Төрийн бус байгууллага ба татвар



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БА ТАТВАР



Төрийн бус байгууллага гэж юу вэ ?

Улс орнуудын орон нутгийн, сайн дурын байгууллагууд, албан бус секторын үйл ажиллагааг тодорхойлохын тулд анх НҮБ, хожим нь олон улсын болон хандивлагч байгууллагууд “төрийн бус байгууллага” (ТББ) гэсэн нэр томъёог хэрэглэжээ. ТББ гэж өөрсдийн санаачлагаар байгуулсан, байгууллагынхаа зорилго, зорилтыг биелүүлэхийн төлөө бие сэтгэлээ өгсөн, нийтлэг нэгэн зорилго бүхий иргэд эвлэлдэн нэгдэн ажиллахыг хэлнэ.

Ихэнхи орнуудад ТББ-ын үйл ажиллагаа Үндсэн хууль, эсвэл өөр бусад хуулиар зохицуулагдсан байдаг. Монгол улсад ТББ-ын эрх зүйн үндсийг 1997 онд гарсан “ТББ-ын тухай хууль”-иар баталгаажуулсан билээ. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д “Төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас өөр бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

“Нийгэмд шийдэгдээгүй асуудал хичнээн их байна, ТББ-ууд төчнөөн олон байх магадлалтай” гэж улс төр судлаачид бичсэн байдаг. Мөн “Улс орны хөгжлийн түвшинг тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын тоогоор тодорхойлдог” гэсэн нэгэн үзүүлэлт байдаг юм билээ.

Дэлгүүрээс худалдан авсан өнгөт телевизорын өнгө нь долоо хоногийн дараа гарахаа больчихлоо. Засварчин дуудаж үзүүлэхэд “үйлдвэрийн брак” гээд явчихлаа. Та одоо яах вэ? Хаана хандах вэ? Мэдээж, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс тусламж хүснэ.

Таны хүүхэд 10-р ангиа төгсөх гэж байна. Цаашид ямар мэргэжил эзэмшүүлэх, гадаад дотоодын аль сургуульд суралцуулах, энэ тухай хамгийн дөт, бодит мэдээллийг хаанаас авахаа мэдэхгүй байвал Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төв болон Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв Танд тодорхой мэдээллээр үйлчилнэ.



Гэр бүл, хамаатан садангийн тань хүн ямарваа нэгэн хүчирхийлэлд удаа дараа өртөж, сэтгэл санааны болон бие бялдрын байнгын дарамтанд орж яахаа мэдэхгүй байгаа бол ... Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хүчирхийлэлд өртөгсдийг хамгаална.

Та төрийн бус байгууллага байгуулах болон хэрхэн ажиллуулах талаар зөвлөгөө авах, эсвэл ТББ-уудын тухай сүүлийн үеийн мэдээ мэдээллүүдийг авмаар байгаа бол Ардчиллын Боловсрол Төв Танд энэ бүх мэдээлэл, үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх болно.

Дээрхи болон бусад олон төрлийн үйлчилгээг манай ТББ-ууд үзүүлж байгаа юм. 2004 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар Монголын ТББ-уудын тоо 4200 хүрээд байна. ТББ-ууд гэдэг нь төр, засгийн шийдвэрлэх ёстой боловч хийгддэггүй, нийгэмд болон орчин тойронд тулгамдаж буй асуудлуудыг соргоогоор харж, идэвхи зүтгэлтэй шийддэг, бид бүгдийн өдөр тутмын амьдралыг илүү гэгээтэй, сайхан болгох зорилго бүхий, сайн дураараа эвлэлдэж зохион байгуулалтанд орсон сайн санаат хүмүүсийн нэгдлүүд юм. Тэд өөрсдийн цаг зав, мэдлэг чадвар, боломж бололцоогоо бусдын тусын тулд зориулж буй буянт хүмүүс юм.

ТББ-ууд төр засгийн үйл ажиллагаа, үйлчилгээний ачааллыг хөнгөвчилж нөөц зардлыг нь хэмнэж байгаа билээ. ТББ-ыг төрийн байгууллагуудтай харьцуулбал иргэдийн ашиг сонирхлыг бага зардлаар, илүү үр дүнтэй хамгаалж, тэдэнд үйлчилдэг. Төрийн нүсэр, хүнд сурталд автагдсан аппаратаас илүү жижиг, тодорхой зорилготой ТББ нь иргэд бөгөөд нийгэмд харьцангуй ойр ажилладаг хийгээд тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хамгийн сайн мэдэж тодорхойлж чаддаг билээ.

Хөгжилтэй орнуудын туршлагаас харахад төр нь төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих үүднээс татвараас аль болох хөнгөлөх, чөлөөлөх, тэр тусмаа бизнесийнхний татварын тодорхой хувийг иргэний нийгэм, ТББ-ууддаа зориулж байна. Энэ нь эргээд улс орондоо хөрөнгө оруулалт хийж байна гэсэн үг юм. Иргэд өөрсдийн хүсэл эрмэлзлэлээр ТББ-ын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, оюун санаа болон эд материалын дэмжлэг туслалцааг нийгмийн сайн сайхны төлөө хандивлах эрхээ эдлэх нь зүй ёсны хэрэг. Харин ТББ-ууд хуулийн дагуу зохих татвараа төлөх нь тэдний үүрэг юм.



Төрийн бус байгууллага ба татвар

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц гүнзгийрэх тусам татварын тогтолцоог боловсронгуй болгох, бүртгэл хөтлөлт, татварын тооцооллын асуудлыг сайжруулахын зэрэгцээ татварын боловсролыг дээшлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Монгол улсад 1993 оноос татварын багц хууль хэрэгжиж, хамгийн бага зардлаар татварын орлогыг цуглуулах сонгодог арга болох татвар төлөгч өөрөө орлого татвараа тодорхойлж төлдөг шинэ тогтолцоонд шилжсэн нь энэ тогтолцооны гол субъект болох татвар төлөгчдийн татварын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагыг улам өндөржүүлж байгаа юм.

Нийгмийн соёл, боловсрол, эрүүл мэнд, эмзэг хэсэг, улс орны өнгө төрхийг өнөөгийн дэлхий нийтийн хөгжлийн түвшингээс хоцроохгүй авч явж, улам хөгжүүлэх үндсийг татвар төлөгч бүрийн хуулийн дагуу оруулсан хувь нэмрээс бүрдсэн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байдаг. Монгол улсын Татварын ерөнхий хуульд «Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд, тодорхой хугацаанд, тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ» гэж заасан болохоор иргэн, хуулийн этгээдүүд нь хуулиар ногдсон үүргээ заавал биелүүлэх үүрэгтэй төдийгүй түүгээрээ бахархаж, иргэний үүргээ нэр төртэй биелүүлж байгаа хэрэг гэж үздэг. Энэ үүргийн биелэлт нь төрийн удирдлагаасаа эхлээд иргэн, хуулийн этгээд бүрийн хүчин зүтгэлээс хамаардаг, өөрөөр хэлбэл оролцогч талуудын ухамсарт үйл ажиллагаа юу юунаас ч чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Монгол улсын Төрийн бус байгууллагын хууль 1997 онд батлагдаж хэрэгжсэнээс хойш төрийн бус байгууллагууд нь хуулийн хүрээнд ажиллаж, татварын багц хуулийг



хэрэгжүүлж, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар (ААНБОАТ) болон Хүн амын орлогын албан татвар (ХАОАТ)-ыг голлон төлж ирсэн байна. Монгол улсын ААНБОА Татварын хуулийн 3 дугаар зүйлийн 4-т: «Төрийн бус байгууллага татвар төлөгч байна» гэсэн заалтыг 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн өөрчлөлтөөр оруулсан нь төрийн бус байгууллагын төсвийн өмнө хүлээх үүргийг нь тодруулж өгсөн.

Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих үүднээс 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн өөрчлөлтөөр ААНБОА татварын хуулийн 7.1.2-т Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив, 7.1.7-д Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, 7.1.8-д нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив, ХАОАТ-ын 9.1.14-д иргэдээс боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив зэрэг орлогуудыг татвар ногдох орлогоос чөлөөлөхөөр хуульд оруулсныг 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн өөрчлөлтөөр ААНБОА татварын хуулийн 7.1.7-г Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого гэж өөрчлөн, 7.1.8-д заасныг хүчингүй болсонд тооцсон байна.


Монгол улсад 2004 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 4200 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2002 онд Нийслэлийн 6 дүүргийн (Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул) татварын албанд нийт 516 ТББ бүртгэгдэж, 426,8 сая төгрөгийн татварыг улсын төсөвт оруулсан бөгөөд үүнээс 9,0 сая төгрөгийг ААНБОАТ, 365,6 сая төгрөгийг ХАОАТ, 19,8 сая төгрөгийг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, 32, 3 сая төгрөгийг бусад татварт төлжээ. Харин 2003 онд 583,6 сая төгрөгийн татварыг төсөвт оруулснаас 25,2 сая төгрөгийг ААНБОАТ, 503,9 сая төгрөгийг ХАОАТ, 1,0 сая төгрөгийг НӨАТ, 44,1 сая төгрөгийг ҮХХАТ, 9,3 сая



төгрөгийг бусад татварт төлсөн байна. Дээрх ТББ-ууд 2002 онд 0,7 сая, 2003 онд 75,6 сая төгрөгийн албан татварын чөлөөлөлтийг (ААНБОАТ-ын хуулийн 7.1.2. “Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандиваас чөлөөлөгдөнө”) тус тус эдэлсэн байна.

Нийслэлийн 6 дүүрэгт харьяалах төрийн бус байгууллагуудад гарч байгаа алдаа оноо, зөрчил дутагдлыг 2002, 2003 оны байдлаар судалж үзэхэд нийт шалгалтад хамрагдсан төрийн бус байгууллагуудын 66.9 хувь нь ямар нэг зөрчилтэй, үүнээс 39.2 хувь нь бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох албан татварын дундын суутгал хийгээгүй, 23.2 хувь нь ХАОА татварыг суутгаагүй буюу дутуу суутгасан, 18.4 хувь нь татвараа хугацаанд нь төлөөгүй, 5.8 хувь нь үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулж төлөөгүй, 3.9 хувь нь баримтгүй зардлыг татвар ногдуулах орлогоос хассан зөрчлүүд зонхилж байлаа. Бодит байдалд гарч байгаа зөрчил болон төрийн бус байгууллагуудын удирдлага, хамт олны сонирхсон асуудлуудыг судалсны үндсэн дээр мөрдөгдөж байгаа хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргачлал, журам, зааврыг ийнхүү гарын авлага болгон бэлтгэнгаргаж байгаа нь нийт төрийн бус байгууллагуудын хэмжээнд эдгээрийг нэг мөр зөв ойлгон ажил албандаа хэрэгжүүлэх бололцоог нэмэгдүүлэх юм.

Төрийн бус байгууллагууд нь улс орны хэмжээнд тулгамдсан асуудлуудыг өөрсдийн оюун санаа, итгэл үнэмшлээрээ шийдвэрлэхээр эвлэлдэн нэгдэж, төсвөөс дэмжлэг тусалцаа авалгүйгээр ашгийн төлөө биш зөвхөн үүсгэн байгуулсан зорилгоо хэрэгжүүлэх зардлыг нөхөх үүднээс нийгмийн сайн сайхны тусын тулд ажиллаж, түүнээсээ зохих хуулийн дагуу татвараа төлж байдгаараа бусад татвар төлөгчөөс өвөрмөц онцлогтой.



II бүлэг

*Аж ахуйн нэгж,
байгууллагын
орлогын
албан татвар*





Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар

Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар (ААНБОАТ)-ын хууль нь 1992 оны 12 дугаар сарын 14-нд батлагдаж 1993.11.03, 1994.07.04, 1997.04.17, 1997.10.30, 1997.12.05, 1998.01.09, 1998.01.15, 1998.11.06, 1999.01.22, 1999.05.12, 2000.02.03, 2000.11.17, 2001.01.25, 2001.11.09, 2002.12.05, 2003.11.27, 2004.04.23-нд нэмэлт өөрчлөлт орсон.

Аж ахуйн нэгж байгууллага олсон орлогоосоо Монгол улсын ААНБОА татварын хуульд заагдсан зардлуудыг хасч татвар ногдуулах орлогыг тодорхойлж, түүнд ногдуулан төсөвт төлж байгаа мөнгөн хөрөнгийг Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар гэнэ. Аж ахуйн нэгж байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд үндэслэн аккруэл сууриар (*орлого зардлыг мөнгө хүлээн авсан, төлсөн эсэхээс нь ул хамаарч, ажил гүйлгээ хийгдсэн үед нь хүлээн зөвшөөрөх*) хөтөлж, санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн гаргаж тодорхойлсон ашгийн хэмжээг үндэслэн Монгол улсад мөрдөж байгаа ААНБОА татварын хуульд заасны дагуу **татвар ногдуулах орлогыг** тодорхойлдог. Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн болон татварын тайлангийн хоорондын зөрүүг Сангийн сайдын 1997 оны 429 тоот тушаалаар батлагдсан журмаар уялдуулан зохицуулж байна.

1992 онд батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулиар албан татвар төлөгч нь гагцхүү ашгийн төлөө байгууллагууд байна гэж заажээ. 1997 оны “Төрийн бус байгууллагын тухай” хуульд төрийн бус байгууллагыг ашгийн төлөө бус байгууллага гэж томъёолсон боловч 1997 оны Татварын ерөнхий хуульд орсон өөрчлөлтөд “тус улсын нутаг дэвсгэрт оршин байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, сан”, ААНБОАТ-ын 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар “төрийн бус байгууллага нь албан татвар төлөгч байна” гэж заажээ.

Хуулийн заалт

ААНБОАТ-ын хуулийн 3 дугаар зүйл:

Албан татвар төлөгч

1. Дараахь аж ахуйн нэгж, байгууллага албан татвар төлөгч байна:

1) Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж

2) Монгол улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар

3) Арилжааны банк, зээл, даатгалын болон тэдгээртэй адилтгах бусад байгууллага

4) Төрийн бус байгууллага

5) Шашны байгууллага

6) Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

7) Энэ хэсгийн 1-7-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд.

/Энэ хэсэгт 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар 4-7 дахь заалтыг нэмж, 2001 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/.

Тайлбар

ҮТЕГ-ын даргын 2002 оны 2 тоот тушаалаар баталсан ААНБОАТ-ын хуулийг хэрэгжүүлэх аргачлалын дагуу **Төрийн бус байгууллага гэж:**

1) Иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шууд эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг **ашгийн төлөө бус байгууллага**. Жишээ нь: Хамтын ажиллагааны нийгэмлэгүүд, найрамдлын нийгэмлэгүүд гэх мэт...

2) “**Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага**” гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин аж ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг хэлнэ. Жишээ нь: Мэргэжлийн холбоод, Хүний эрхийн төв...

3) “**Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага**” гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагыг хэлнэ. Жишээ нь: Зочид буудлуудын холбоо, Хувийн эздийн холбоо, г.м.

Төрийн бус байгууллага нь үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталсан төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.



Санамж

- Монгол улсын Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 5-р зүйлд «...шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллага нь бүртгэх байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 3 хоногийн дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн бүртгүүлнэ» гэж заасны дагуу бүртгүүлнэ.
- Төрийн бус байгууллага нь албан татварын хуулийн дагуу татварын тайлангаа улирал бүр дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийнхээ тайлан тэнцлийг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ татварын албанд тушаана.

Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх

ААНБОАТ-ын хуулийн 7 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх

1. Албан татвар төлөгчийн дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:

2) Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив

7) Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого

/энэ заалтыг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.

18) Хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа

50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүн ажилладаг аж ахуйн нэгж,

байгууллагын орлогын албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын

нийт ажиллагсдад тахир дутуу хүмүүсийн эзэлж байгаа хувиар хөнгөлнө.

/энэ заалтыг 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/.

ЖИШЭЭ БОДЛОГУУД

БОДЛОГО 1

1. «А» нь нийгэмд үйлчилдэг ТББ гэж Хууль зүй дотоод хэргийн яамнаас гэрчилгээ авчээ. Өөрийн үйл ажиллагааны хүрээнд жилд 2 төрлийн бүтээл тус бүрийг нь 500 ширхэгээр тогтмол хэвлэж, олны хүртээл болгодог. Үйл ажиллагаагаа санхүүжүүлэх үүднээс дээрх бүтээлүүдээ нэг ширхэгийг нь 2000 төгрөгөөр борлуулдаг бол татварыг хэрхэн тооцож төлөх вэ?

Хариу:

Хэвлэн нийтлэлийн үйл ажиллагаа нь «А» ТББ-ын нийгэмд үйлчлэхээр дүрэмд нь заасан чиглэлийн ажил тул түүнээс орох $2 \times 500 \times 2000 = 2,000,000$ төгрөгийн орлогыг ААНБОАТ-ын хуулийн 7 дугаар зүйлийн 1-ийн 7-д заасны дагуу татвар ногдох орлогоос чөлөөлнө.



ААНБОО татвар ногдох орлогын нэгдсэн зураглал

Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын Хууль зүй дотоод хэргийн яамнаас олгосон төрийн бус байгууллагын гэрчилгээг үндэслэн, нийгэмд үйлчлэхээр дүрэмд заагдсан чиглэлийн үйл ажиллагаанаас бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлогод нь ААНБОО татвар ногдох болно.

ТББ-д хамаарч болох татвар ногдох орлогын төрөл /хуулийн 4 дүгээр зүйл, УТЕГ-ын даргын 2002 оны 2 тоот тушаалаар баталсан аргачлалд зааснаар/

Татвар ногдуулах орлогыг тодорхойлох

Татварын хувь хэмжээ, татвар төлөх, тайлагнах

Нэг. Шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын талаар

1. Үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний орлого /борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний бүх орлого хамаарагдана/

10. Зээллэгийн хүүгийн орлого /бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого хамаарна. Улсын зээллэг, бусад үнэт зүйлсээс орох орлого болон тэдгээрийн борлуулалттай холбогдон үүсэх урамшууллын орлогоос мөнгөн болон эд хөрөнгийн зээлийн үйл ажиллагаанаас олсон хүүгийн орлого орно/

11. Хөрөнгө түрээслүүлсний орлого /өөрийн өмчлөлд буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэндээ байгаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулсны төлөө авч буй төлбөрийг хэлнэ/

ТНО = НО - ХЗ

ТНО -татвар ногдуулах орлого

НО -нийт орлого

ХЗ -хасагдах зардал

Эдгээр орлогуудаас баримтаар нотлогдож буй шууд зардал, үүнд цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс, бүх төрлийн материалын зардал, хагас боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав баглаа боодлын зардал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл, урсгал засварын зардал, гадаадын валютын арилжаанаас гарах алдагдал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, түрээсийн төлбөр, зээлийн хүү, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөрийг хассан зөрүүгээр. Төсөвт төлсөн онцгой болон үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг албан татвар

Албан татвар ногдуулах жилийн орлогод дараахь хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

1. **0-100.000.000** төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлогод **15%**

2. **100.000.000**-аас дээш төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлогод **15.000.000 төгрөг дээр 100.000.000 төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 30 хувиар нэмж** татвар ногдуулна.

Албан татвар төлөгч албан татварын хэмжээг нягтлан бодох бүртгэлийн улирал, жилийн тайлан тэнцлийг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр өөрөө тодорхойлж төсөвт төлнө. Жилд төлөх татвараа сар бүр 25-ны дотор урьдчилан төлж, улирлын албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2-р сарын 10-ны дотор татварын албанд тушааж, албан татварын эцсийн тооцоо хийнэ.



12. Зуучлах үйл ажиллагааны орлого /ашиг сонирхол бүхий этгээдүүдэд үйлчлэн тэднийг холбож өгсний болон аливаа үйл ажиллагааг бусдын нэрийн өмнөөс гүйцэтгэсний төлөө тэднээс авсан төлбөр (орлого)-ийг хэлнэ/

15. Гадаад валютын арил - жаанаас олох орлого / гадаад валютын арилжаа эрхлэх эрх бүхий татвар төлөгчийн энэ үйл ажиллагаанаас олж байгаа ханшны зөрүүгийн орлогыг хэлнэ/

16. Албан татвар ногдох бусад орлого /хандив, бэлэглэл, шагнал, хууль, тогтоомж, гэрээний дагуу бусдаас авсан хүү торгууль, нэхэмжлэгч нь тодроогүйгээс зохих байгууллагаас эзэмших эрхийг нь олгосон олз, тооллогоор илүүдсэн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үнэ зэргийг хамааруулна/

7. Хөдлөх хөрөнгө борлуулсны орлого /үл хөдлөх хөрөнгөнөөс бусад үндсэн ба эргэлтийн бүх төрлийн хөрөнгө борлуулсны орлого хамаарна/

ногдуулах орлогоос хасч тооцно.

Заавал даатгуулах даатгалын хураамжийг албан татвар ногдуулах орлогоос хасна. Зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг гүйцэтгэлээр нь тооцох боловч, тэдгээрийн нийлбэр нь тухайн аж ахуйн нэгж байгууллагын татвар ногдуулах орлогын 10%-иас хэтэрч болохгүй. Хөрөнгө оруулалт, их засварын зардал, бүх төрлийн шагнал, урамшуулал, тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, хэвлэл захиалга, ажиллагсдад олгож байгаа байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, байр түлшний үнийн хөнгөлөлт, сайн дурын даатгалын хураамж, бараа материалын хэвийн хорогдол, хугацаа хэтэрсэн зээлийн хүү, бүх төрлийн торгууль болон албан татвар төлөгчийн буруугаас бусдад учруулсан хохирлын нөхсөн төлөөс зэрэг зардлыг албан татвар ногдуулах орлогоос хасахгүй.

Орлогоос уг хөрөнгийн үлдэгдэл өртгийг хассан зөрүүгээр

Хоёр. Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын талаар

6. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого /үл хөдлөх эд хөрөнгөд газар түүнээс салгаж хэрэглэж үл болох зүйл хамаарах бөгөөд уг хөрөнгийг худалдан борлуулсны орлого үүнд хамаарна/

Орлогын нийт дүнгээр

Орлогын дүнд 2 хувиар албан татвар ногдуулна. Уг хөрөнгийг борлуулснаас хойш 10 хоногийн дотор төсөвт төлнө. Тайлагнах хугацаа өмнөхтэй адил



8. Эрхийн шимтгэлийн орлого / уран зохиол нийтлэх, урлаг, уран сайхан болон шинжлэх ухааны техникийн нээлт, бүтээл, патент, барааны тэмдэг, дизайн, загвар, зураг төсөл, нууц томъёолол буюу процессыг ашиглах, үйлдвэрлэл, худалдаа, шинжлэх ухааны багаж хэрэгсэл болон туршлагатай холбогдсон мэдээлэл зэрэг оюуны бүтээл эзэмших эрх, уг эзэмшсэн эрхээ бусдад ашиглуулсны төлөө авч буй төлбөр, шимтгэл хамаарна/

Орлогын нийт дүнгээр

Орлогод 10 хувиар албан татвар ногдуулна.
Олгож байгаа байгууллага, аж ахуйн нэгж суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт төлнө.

13. Хонжворт сугалаа, таавар, тоглоомын орлого /бүх төрлийн төлбөрт тоглоом тоглуулах, видео болон аудио хуурцаг худалдах, түүний бичлэгийн хөлсний үйлчилгээ хийх, видео үзвэр болон хонжворт сугалаа, тааварт тоглоом зэргийн орлого үүнд хамаарна/

Орлогоос уг орлогыг олохтой холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хассан зөрүүгээр

Орлогод 40 хувиар албан татвар ногдуулна.

14. Банкнаас авсан хүүгийн орлого /харилцах дансны тогтвортой үлдэгдэлд болон сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө хадгалуулсны төлөө банкны байгууллагаас авч байгаа хүүгийн орлогыг үүнд хамааруулна/

Орлогын нийт дүнгээр

Орлогод 15 хувиар албан татвар ногдуулна.
Олгож байгаа байгууллага, аж ахуйн нэгж суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт төлнө.

Гурав. Монгол улсад оршин суугч бус хуулийн этгээдэд шилжүүлэх орлогын талаар

Мөн хуулийн 6.1.7. Монгол улсад оршин суугч бус хуулийн этгээдийн Монгол улсад олсон орлого:
б/ Зээлийн хүү, батлан даалт гаргасны төлбөр;
в/ Эрхийн шимтгэлийн орлого, түрээсийн төлбөр, биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого;
г/ Монгол улсын төрийн байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгууллага, хувь хүнд үзүүлсэн техникийн болон бусад үйлчилгээний орлого; татвар ногдуулах орлого байна гэж заасныг үндэслэн тухайн үйлчилгээг авсныхаа төлөө оршин суугч бус татвар төлөгчид төлбөр төлж байгаа аж ахуйн нэгж байгууллага дээрх орлогын нийт дүнд 20 хувиар албан татвар ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт төлнө.

Үндсэн хөрөнгийг дор дурдсан хугацаатай ашиглахаар бодож үндсэн хөрөнгийн элэгдэл хөрөгдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар байгуулна.

Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жилээр/	Жилд байгуулах элэгдлийн хувь
1. Байшин, барилга, байгууламж	40	2,5
2. Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10	10
Үүнээс: Шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, туршилтын болон тэргүүний технологи, экспортын болон уул уурхайн үйлдвэр, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх, дэд бүтцийн салбарын тусгай зориулалтын машин техник, тоног төхөөрөмж, компьютер /компьютер 2001-11-09-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/	5	20
3. Бусад үндсэн хөрөнгө	10	10

ЖИШЭЭ БОДЛОГУУД

БОДЛОГО 1

«Х» ТББ үйл ажиллагааныхаа хэрэгцээнд 2 компьютер шинээр худалдан авчээ. 900000 төгрөгөөр 4 жилийн өмнө худалдан авсан хуучин компьютераа 2004 оны 1-р улиралд байгууллагынхаа нэг ажилтанд 300000 төгрөгөөр худалдсан бол хэдэн төгрөгийн татвар ногдох вэ?

Хариу:

- Ашигласан хугацаанд байгуулсан элэгдэл: (2002-01-01-нээс эхлэн компьютерийн ашиглах хугацааг 5 жил болгосон).
 $(900000 \times 10\% \times 2 \text{ жил}) + (900000 \times 20\% \times 2 \text{ жил}) = 180000 + 360000 = 540000$ төг
- Үлдэгдэл өртөг: $900000 - 540000 = 360000$ төг
- Татвар ногдуулах орлого: $300000 - 360000 = -60000$ татвар ногдуулах орлогогүй байх тул татвар ногдохгүй.

**БОДЛОГО 2**

“Б” ТББ-ын харилцах дансны тогтвортой үлдэгдэлд банк 100.000 төгрөгийн хүү олгосон бол татварыг хэрхэн тооцох вэ? Хэн энэ татварыг суутгах вэ?

Хариу:

1. $100.000 \times 15\% = 15.000$ төгрөгийг тус банк нь суутгаж төсөвт төлнө.

БОДЛОГО 3

“Г” ТББ нь гадаад, дотоодын ТББ-уудын хооронд зуучлалын үйл ажиллагаа явуулснаас 2,0 сая төгрөгийн орлого олж, 1,8 сая төгрөгийн баримтаар нотлогдох зардал гаргажээ. Зуучлал нь тухайн байгууллагын зорилгод нийцсэн үйл ажиллагаа биш бол албан татварыг хэрхэн тодорхойлох вэ?

Хариу:

1. ТНО = Нийт орлого – Хасагдах зардал = $2.000.000 - 1.800.000 = 200.000$
2. Ногдох татвар = ТНО $\times 15\% = 200.000 \times 15\% = 30.000$ төгрөгийн татварыг төлнө.

БОДЛОГО 4

“Н” ТББ 10 сая төгрөгөөр авсан суудлын машинаа 2 жил ашиглаад 13 сая төгрөгөөр худалдсан, тайлант хугацаанд 4,800.000 төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргасан бол татвар ногдуулах орлого болон ногдох татварыг тодорхойлно уу?

Хариу:

1. Борлуулалтын орлого: 13,000.000 төгрөг
2. Үйл ажиллагааны зардал: 4,800.000
3. Уг машиныг ашигласан хугацаанд байгуулсан элэгдэл: $10.000.000 \times 10\% \times 2 \text{ жил} = 2.000.000$ төг
4. Борлуулсан машины үлдэгдэл өртөг: $10.000.000 - 2.000.000 = 8.000.000$ төг
5. ТНО /Татвар ногдуулах орлого/: $13.000.000 - (8.000.000 + 4.800.000) = 200.000$ төгрөг
6. Ногдох татвар = ТНО $\times 15\% = 200.000 \times 15\% = 30.000$ төгрөг болно

БОДЛОГО 5

“Ц” ТББ нь өөрийн эзэмшилд байдаг конторын барилгын 2 өрөө байрыг гадны байгууллагад түрээслүүлж сард 800.000 төгрөгийн орлого олдог. Уг орлогыг олохтой холбогдож сард 250.000 төгрөгийн, бичиг хэргийн, удирдлагын болон хуульд заагдсан хасагдах бусад зардалд 464.000 төгрөг гаргасан бол албан татварын тооцоог хэрхэн хийх вэ?

Хариу:


1. Сарын борлуулалтын орлого /БО/: 800.000 төгрөг
2. Хасагдах зардал /ХЗ/: $(250.000 + 464.000) = 714.000$ төгрөг
3. Татвар ногдуулах орлого: $\text{ТНО} = \text{БО} - \text{ХЗ} = 800.000 - 714.000 = 86.000$ төгрөг
4. Ногдох татвар: $\text{ТНО} \times 15\% = 86.000 \times 15\% = 12.900$ төгрөг төлнө.

БОДЛОГО 6

“М” ТББ нь НӨАТ төлөгч биш жижиг байгууллага. Энэ улирлын борлуулалтын орлого нь 300.000 төгрөг байв. Гэтэл тогтмол захиалдаг хэвлэлүүдийн нэгэнд нь хонжворт сугалаа таарч 110.000 төгрөгийн телевизорээр шагнуулжээ. Улирлын нийт хасагдах зардал нь 390.000 төгрөг бол энэ улирлын татварын тооцоог хийнэ үү.


Хариу:

1. “М” ТББ нь хонжворт таарсан 110.000 төгрөгийн үнэтэй телевизорыг бүртгэлдээ тусгаж, орлогод авч татвар ногдох орлогод тооцно. Ингэвэл нийт орлого нь $300.000 + 110.000 = 410.000$ төгрөг болно.
 2. Нийт хасагдах зардал нь 390.000 төгрөг
 3. Тэгвэл энэ улирлын $\text{ТНО} = 410.000 - 390.000 = 20.000$ төгрөг
 4. Төлбөл зохих татвар $= 20.000 \times 15\% = 3.000$ төгрөг төлнө.
- Хонжворыг хожсон тул бусад орлого гэдэг утгаар ойлгогдоно. Харин хонжворт тоглоомын орлогод орохгүй.



III бүлэг

*Хүн амын
орлогын
албан татвар*





Хүн амын орлогын албан татвар

Монгол улсын Хүн амын орлогын албан татварын (ХАОАТ) хууль нь 1992 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан ба 1993, 1994, 1997, 1998, 1999, 2000, 2001, 2002, 2003, 2004 онд өөрчлөлт, нэмэлт орсон.

Иргэдийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, аж ахуй эрхэлсний орлого, хувиараа бараа материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого, хөрөнгийн хөдлөл, эрхийн орлого, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого, урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагнал, бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого болон албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлогод ногдуулдаг татварыг хүн амын орлогын албан татвар гэнэ.

Хүн амын орлогын албан татвар төлөгч /ХАОАТ хуулийн 3 дугаар зүйл/		Татвар ногдох орлого	Татвар төлөгчийн бүртгэл
• Монгол улсын иргэн	Байнга оршин суугч	Монгол улсад болон гадаадад олсон орлогоосоо	5.1. «байнга болон түр оршин суугч татвар төлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ татварын албанд бүртгүүлж, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авна» 5.3. «татварын алба нь татвар төлөгчийн дугаар бүхий гэрчилгээг татвар төлөгчид олгоно»
• Монгол улсад оршин суугаа харьяалалгүй хүн	Түр оршин суугч	Монгол улсад олсон орлогоосоо	
• Монгол улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд	Оршин суугч бус		

• Аж ахуйн нэгж, байгууллага нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэнэ.

Хүн амын орлогын албан татвар ногдох орлогын нэгдсэн зураглал

Татвар ногдох орлогын төрөл

/хуулийн 4 дүгээр зүйл, УТЕГ-ын даргын 2002 оны 12 тоот тушаалаар баталсан аргачлалд зааснаар/

Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох /ХАОАТ-ын хуулийн 5 дугаар зүйл/

Сар бүр суутгах хэмжээ

Жилийн орлогод ногдуулах Албан татварын хувь, хэмжээ /ХАОАТ-ын хуулийн 7 дугаар зүйл/

Нэг. Шаталсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын талаар

1.1. цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого
а/ аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого

нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан зөрүүгээр

0-200.000 төгрөгийн орлогод - 10%
200.001 - 400.000 төгрөгийн орлогод: 20.000 төгрөг дээр 200.000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20%
400.001, түүнээс дээш төгрөгийн орлогод: 60.000 төгрөг дээр 400.000 төгрөгөөс дээш дүнгийн 30%

Шатлалын дагуу төлөхөөр тооцогдсон **сарын татвараас 4000 төгрөгийг /48000:12/ хөнгөлж хасна.**

0-2.400.000 төгрөгийн орлогод - 10%
2.400.001 - 4.800.000 төгрөгийн орлогод: 240.000 төгрөг дээр 2.400.000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20%
4.800.001, түүнээс дээш төгрөгийн орлогод: 720.000 төгрөг дээр 4.800.000 төгрөгөөс дээш дүнгийн 30%
9.3/ Шатлалын дагуу төлөхөөр тооцогдсон жилийн татвараас 48000 төгрөгийн татварыг хөнгөлнө.

3/ Аж ахуй эрхэлсний орлого

Нийт орлогоос баримтаар нотлогдож буй зардлыг хассан зөрүүгээр. Гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг НД шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож зардалд тооцно. Аж ахуй эрхлэгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг зардалд тооцохгүй.

Аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс суутган авсан албан татварыг дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлэн, албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяалагдах татварын албанд тушаана.



<p>5.в. Хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого</p>	<p><u>нийт орлогоос</u> ийнхүү түрээслүүлсэнтэй холбогдон <u>гарсан зардлыг хассан зөрүүгээр</u></p>		<p>Иргэн 1-ээс дээш аж ахуйн нэгж, байгууллагаас цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, аж ахуй эрхэлсний, хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны, хөрөнгө түрээслүүлсний болон бусад орлого авдаг бол жилийн эцэст орлого татвар тодорхойлох хуудсаар жилд олсон нийт орлого болон төлсөн татвараа нэгтгэн тодорхойлж, албан татварын жилийн тооцоог дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор хийнэ.</p> <p>«Татвар төлөгч энэ хуулийн 4-р зүйлийн 1 дэх хэсгийн 1,3,4,9, мөн хэсгийн 5 дахь заалтын □в□-д заасан орлого авдаг бол уг орлогод энэ хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар албан татвар ногдуулан төлж, орлого, татвар тодорхойлох хуудсаар албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ» /Хуулийн 10.8/</p>
<p>9/ Энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого</p>	<p><u>Орлогын дүнгээр</u></p>		<p>«Орлогын үндсэн эх үүсвэрээс гадна үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого</p>
<p>1.1.б/ үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан <u>гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого</u></p>	<p>гэрээний үндсэн дээр авсан <u>орлогын нийлбэр дүнгээр</u></p>	<p><u>10 хувиар</u> /Орлого олгох бүртгэ дундын суутгал хийж, суутгасан албан татварыг төсөвт шилжүүлж, энэ тухай иргэний орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна/</p>	<p>үнийн дүнгийн <u>3%-иар</u> дундын суутгал хийнэ. /энэ тухай ИОТТ хуудсанд тэмдэглэж, баталгаажуулна/</p> <p>«Орлогын үндсэн эх үүсвэрээс гадна үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж байгууллага болон иргэдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин, түүнтэй адилтгах бусад орлого, бараа материал, түүхий эд худалдсаны орлоготой иргэн нь оршин сууж буй нутаг дэвсгэрийн татварын албанд татвар төлөгчөөр заавал бүртгүүлж, орлого олох бүрдээ татвар төлөгчийн орлого татварын бүртгэлийн дэвтэрт уг орлогыг олгож, татварыг нь суутган авсан ААНБ, иргэнээр тэмдэглэгээ хийлгэж, гарын үсэг зуруулан, тэмдэг даруулж баталгаажуулах ба албан татварын жилийн тооцоог ИОТТХуудас/ТТ-06 маягт/-аар хийж, харьцагч татварын албанд дараа оны 2-р сарын 15-ны дотор ирүүлнэ» /ҮТЕГ-ын даргын 2002 оны 129-р тушаалаар батлагдсан ХАОАТатвар төлөгчийг тодорхойлж бүртгэх, татварын тооцоо хийх журмын 3.1/</p>
<p>4/ Хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого</p>	<p>Нийт орлогоос <u>баримтаар нотлогдож буй зардлыг хассан зөрүүгээр</u></p>	<p>үнийн дүнгийн <u>3%-иар</u> дундын суутгал хийнэ. /энэ тухай ИОТТ хуудсанд тэмдэглэж, баталгаажуулна/</p>	

Хоёр. Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын талаар

<p>5.а Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, адилтгах бусад орлого</p>	<p><u>орлогын дүнгээр</u></p>	<p><u>2 хувиар тусгайлан ногдуулна.</u></p>
<p>5.б. Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчдийн орлого</p>	<p>Нийт дүнгээр</p>	<p><u>15 хувиар /2005-01-01-ний өдрөөс дагаж мөрдөнө/</u></p>
<p>5.г. Эрхийн шимтгэлийн орлого /зохиогчийн эрх, программ хангамж, патент, зураг төсөл, загвар, барааны тэмдэг, ноухау, кино, видео, аудио бичлэг, бусад бичлэг ашигласны буюу ашиглах эрх эдэлсний төлбөр, г.м./</p>	<p><u>Орлогын дүнгээр</u></p>	<p><u>10 хувиар тусгайлан ногдуулна.</u> Олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн орлогод ногдуулан суутган авсан татварыг 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.</p>
<p>5.д. зээлийн болон хадгалам - жийн хүүгийн орлого, адилтгах бусад орлого</p>	<p>Орлогын дүнгээр</p>	<p><u>15 хувиар /2005-01-01-ний өдрөөс дагаж мөрдөнө/</u></p>
<p>6) шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгчдийн шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого</p>	<p>шагнал болон адилтгах <u>орлогын дүнгээр</u></p>	<p>шагнал болон адилтгах бусад шагналын <u>5.000.000 хүртэлх</u> төгрөгийн орлогод <u>5 хувиар, 5.000.001, түүнээс дээш</u> төгрөгийн орлогод <u>10 хувиар тусгайлан ногдуулна.</u> <u>Ногдуулан суутган авсан татварыг 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.</u></p>
<p>7) урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагнал</p>	<p><u>орлогын дүнгээр</u></p>	<p>10 хувиар тусгайлан <u>н о г д у у л н а .</u> Ногдуулан суутган авсан татварыг 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.</p>
<p>8) бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого</p>	<p><u>орлогын дүнгээр</u></p>	<p>10 хувиар тусгайлан ногдуулна. Ногдуулан суутган авсан татварыг 3 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.</p>
<p>8.9. гадаад оронд эмнэлэг болон урлаг, уран сайхан, эрдэм шинжилгээ, сурталчилгаа зэрэг оюуны үйлчилгээ явуулсан иргэний уг орлогод</p>	<p><u>орлогын дүнгээр</u></p>	<p>Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол 10%-иар</p>



Тодруулга

«Монгол улсад байнга оршин суугч нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол түүний энэ хуулийн 8-р зүйлийн 1,3,4,5,6,7,8-д /тусгайлан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг орлогоуд/ болон 7 дугаар зүйлийн 5-д заасан орлогод /үндсэн ажлын газраас бусад ААНБ, иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, адилтгах бусад орлого болон бараа материал, түүхий эд борлуулсны орлого/ энэ хуулийн 8*-д заасан 20 хувиар албан татвар ногдуулна»

/Хуулийн 8 дугаар зүйлийн 10/

ААНБ нь үндсэн ажлын газраас бусад ААНБ, иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, адилтгах бусад орлого болон бараа материал, түүхий эд борлуулсны орлогыг «Татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэр»-гүй иргэнд олгох тохиолдолд уг орлогоос хуульд заасны дагуу 20 хувиар бодож, татварыг нь суутган тооцно. ААНБ-аас гарган ирүүлэх ТТ-11.2 ба ТТ-11.3 маягтад «Татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэр»-гүй иргэнд олгосон орлогод ногдох татварыг 20 хувиар ногдуулан суутган тооцсон гэж үзэх ба үүнтэй холбогдон гарах татварын дутууг тухайн ААНБ өөрөө хариуцна. /УТЕГ-ын даргын 2002 оны 129 дугаар тушаалаар батлагдсан ХАОАТатвар төлөгчийг тодорхойлж бүртгэх, татварын тооцоо хийх журмын 3.5/

Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

1. Албан татвараас чөлөөлөх

- ХАОАТ-ын хуулийн 9 дүгээр зүйлийн 1.14: “Иргэдээс боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив”;
- ХАОАТ-ын хуулийн 9 дүгээр зүйлийн 1.15: “Хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүний орлого” -ыг орлогын албан татвараас чөлөөлнө.

/энэ заалтыг ХАОАТ-ын 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/



2. Албан татварт хөнгөлөлт үзүүлэх

ХАОАТ-ын хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “ХАОАТ-ын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод ногдох жилийн татвараас 48.000 төгрөгийн татварыг хөнгөлнө” гэж заажээ.

ХАОАТ-ын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлогод цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого; аж ахуй эрхэлсний орлого; хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого; энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого; хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого зэрэг орно.

Өөрөөр хэлбэл, татвар төлөгч бүрийн сарын орлогод ногдуулсан албан татварын дүнгээс 4.000 төгрөгийг хасч үлдсэнийг цалингаас суутгах буюу олговол зохих цалингаас нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хассан цалингийн дүн нь 40.001 төгрөгөөс дээш байгаа тохиолдолд албан татварын суутгал хийнэ гэсэн үг юм.



ЖИШЭЭ БОДЛОГУУД

БОДЛОГО 1

“А” ТББ нь үндсэн хоёр, нэг түр хугацааны ажилтантай. Үндсэн ажилтны нэг нь 250.000 төгрөг, нөгөө нь 150.000 төгрөг, түр хугацааны ажилтан нь 44.000 төгрөгийн цалин тус тус авдаг бол хүн амын орлогын албан татварыг хэрхэн тодорхойлж суутгах вэ?

Хариу:

Үндсэн 2 ажилтны ХАОАТ ногдуулах орлогыг мөн хуулийн 5.1.1а-д: «Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно» гэж заасны дагуу сар бүрийн цалингаас НДШ, ЭМД-ын 10 хувийг хасч тодорхойлно.

1) Үндсэн ажилтан 1 дүгээр хүний хувьд

- Татвар ногдуулах орлого (ТНО) = (Сарын цалин – НДШ, ЭМД 10%) =
 $250.000 - (250.000 \times 10\%) = 225.000$ төгрөг
- Ногдуулж суутгах татвар = (ТНО х %) - хөнгөлөх татвар =
 $[20.000 + (225.000 - 200.000) \times 20\%] - 4.000 = 21.000$ төгрөг

2) Үндсэн ажилтан 2 дугаар хүний хувьд

- Татвар ногдуулах орлого (ТНО) = $150.000 - (150.000 \times 10\%) = 135.000$ төгрөг
- Ногдуулж суутгах татвар = $(135.000 \times 10\%) - 4.000 = 9.500$ төгрөг

3) Түр ажилтны хувьд

- ногдох татвар = сарын цалин х 10% = $44000 \times 10\% = 4400$ төгрөгийн татвар ногдуулж дундын суутгал хийнэ. Аж ахуйн нэгж байгууллага суутгасан дундын суутгалын татварыг төсөвт шилжүүлж, энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна.

ХАОАТ хуулийн 10.8-д: «Татвар төлөгч энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1,3,4,9, мөн хэсгийн 5 дахь заалтын в-д заасан орлого авдаг бол уг орлогод энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар албан татвар ногдуулан төлж, орлого, татвар тодорхойлох хуудсаар албан татварын жилийн эцсийн тооцоо хийнэ» гэж заасны дагуу «А» ТББ-д гэрээгээр түр ажиллан дундын суутгалын татвар суутгуулсан ажилтан нь оны эцэст харьяалах татварын албанд очиж иргэний орлого татвар тодорхойлох хуудсаар тооцоогоо хийнэ.

**БОДЛОГО 2**

Иргэн Э мэдээлэл технологийн чиглэлийн ТББ-д ажилладаг. Тэрээр мэдээлэл технологийн салбарын мэргэжилтнүүдийн дунд зарласан уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэлжээ. Мэдээлэл технологийн холбооноос түүнд 1 сая төгрөгийн шагнал гардуулжээ. Татварыг хэрхэн тооцох вэ?

**Хариу:**

- ХАОА татварын хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасны дагуу шагнал олгож байгаа мэдээлэл технологийн холбоо нь мөн хуулийн 4.1.1б-д заагдсан / Үндсэн ажлын газраас бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого/ гэсэн заалтад хамруулан 1 сая төгрөгнөөс нь 10 хувиар албан татвар ногдуулж, 100000 төгрөгийн дундын суутгал хийнэ.
- Гэхдээ мөн хуулийн 8 дугаар зүйлийн 10-т заасны дагуу Монгол улсад байнга оршин суугч иргэн Э нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлсэн байх ёстой. Хэрвээ Э нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол мөн хуулийн 8 дугаар зүйлийн 10-г: /Монгол улсад байнга оршин суугч нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол энэ хуулийн 8*-д заасан 20 хувиар албан татвар ногдуулна/ гэж заасны дагуу 20 хувиар суутгал хийнэ.

**Хариу:**

100.000 төгрөгийн дундын суутгал хийнэ. Гэхдээ мөн хуулийн 8 дугаар зүйлийн 10-т заасны дагуу Монгол улсад байнга оршин суугч иргэн Э нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлсэн байх ёстой.

Шагнал авсан иргэн Э нь иргэний орлого, татвар тодорхойлох дэвтрээ үндэслэн тухайн жилд олсон нийт орлого болон төсөвт төлсөн татвараа тодорхойлж, харъяалах дүүргийн татварын хэлтсүүдэд татварын тайлангаа гаргаж, татварын тооцоогоо хийх үүрэгтэй бөгөөд төсөвт төлөх татвар дутуу бол нэмж төлөх, илүү төлсөн бол буцаан авах эсвэл бусад татварын болон дараа жилийн татварт суутган тооцуулах эрхийг эдэлнэ.

БОДЛОГ 3

ТББ-ын ажилтан Г-ийн сарын үндсэн цалин нь 60.000 төгрөг. Үндсэн ажлын зэрэгцээ гэрээгээр нэгэн дээд сургуульд багшилдаг бөгөөд сард 30.000 төгрөгийн хөлс авдаг бол татварыг хэрхэн тооцох вэ?

Хариу:

• Иргэн Г нь үндсэн ажлын газар болох ТББ-д ажиллаж авсан 60.000 төгрөгнөөсөө сар бүр Монгол улсын ХАОА татварын хуулийн 5.1.1-д: «Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно» гэж заасны дагуу НДШ, ЭМД /10%/ 6.000 төгрөгийг хасч гаргасан 54.000 төгрөгийн татвар ногдуулах орлогоосоо мөн хуулийн 7.1-д зааснаар $(54.000 \times 10\%) - 4.000 = 1.400$ төгрөгийн татварыг суутгуулан төсөвт төлнө.

**Хариу:**

- Харин гэрээгээр ажиллаж авсан 30.000 төгрөгийн хөдөлмөрийн хөлснөөс нь хөлс олгогч сургуулийн нягтлан бодогч ХАОА татварын хуулийн 7 дугаар зүйлийн 5а-д заасны дагуу 10 хувиар албан татвар ногдуулж, 3.000 төгрөгийн дундын суутгал хийж төсөвт төлнө. Гэхдээ мөн хуулийн 8 дугаар зүйлийн 10-т заасны дагуу Монгол улсад байнга оршин суугч иргэн Г нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлсэн байх ёстой.
- Давхар орлого олж байгаа иргэн Г нь иргэний орлого, татвар тодорхойлох дэвтрээ үндэслэн тухайн жилд олсон нийт орлого болон төсөвт төлсөн татвараа тодорхойлж, харьяалах дүүргийн татварын хэлтсүүдэд татварын тайлангаа гаргаж, татварын тооцоогоо хийх үүрэгтэй бөгөөд төсөвт төлөх татвар дутуу бол нэмж төлөх, илүү төлсөн бол буцаан авах эсвэл бусад татварын болон дараа жилийн татварт суутган тооцуулах эрхийг эдэлнэ.

**БОДЛОГО 4**

“А” ТББ нь олон улсын бага хурал зохион байгуулж, нэг орчуулагчийг 450.000 төгрөгөөр хөлсөлж ажиллуулжээ. Татварыг хэрхэн тооцох вэ?

**Хариу:**

- “А” ТББ нь ХАОА татварын хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасны дагуу орчуулагчид олгосон 450.000 төгрөгөөс 10 хувиар албан татвар ногдуулж, 45.000 төгрөгийн дундын суутгал хийж төсөвт төлнө. Гэхдээ мөн хуулийн 8 дугаар зүйлийн 10-т заасны дагуу орлого авагч нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлсэн байх ёстой.

**БОДЛОГО 5**

Нийгэмд үйлчилдэг “Б” ТББ-д иргэн “Н” хувиасаа 2,0 сая төгрөгийн хандив өргөжээ. Ямар татвар төлөх вэ?

Хариу:

- ХАОАТ-ын хуулийн 9 дүгээр зүйлийн 1.14-т “Иргэдээс боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандивыг орлогын албан татвараас чөлөөлнө” гэж заасны дагуу Иргэн “Н”-ий тухайн жилийн татвар ногдох орлогоос уг хандивын дүнг чөлөөлнө.



IV бүлэг

*Нэмэгдсэн
өртгийн
албан татвар*





Нэмэгдсэн өртгийн албан татвар

Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль 1998 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөгдөж батлагдсанаасаа хойш 9 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Иргэн, хуулийн этгээдийн импортлосон, экспортлосон бараа, түүнчлэн Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж борлуулсан болон импортлож борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд ногдуулдаг албан татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар гэнэ.

Монгол Улсад анх 1992 онд худалдааны татвар нэртэйгээр энэ татварыг хэрэглэж ирсэн бөгөөд 1998 оны 1 дүгээр сарын 8-нд нэмэгдсэн өртгийн албан татвар нэртэйгээр шинэ хууль батлан мөрдөж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч

Монгол улсын нутаг дэвсгэрт бараа импортлож байгаа болон гүйцэтгэж байгаа түүнчлэн аливаа бараа үйлдвэрлэж борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна. (НӨАТ-ын хуулийн 4.1.)

НӨАТ нь хэрэглээний татвар бөгөөд бусад хэрэглээний татвараас давуу байдал нь:

1. НӨАТатвар төлөгч нь борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ, хөлс дээр НӨАТатвараа 15%-иар тооцон нэмж худалдан авагчдаас нэхэмжилж авдаг.

НӨАТ-ын хуулийн 6 дугаар зүйлийн 1-д: «НӨАТ-ын хуульд өөрөөр заагаагүй бол нэмэгдсэн өртгийн албан татварыг импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний татвар тооцох үнэлгээний 15 хувиар ногдуулна»; 5 дугаар зүйлийн 4-т: «... бараа ажил үйлчилгээнд татвар ногдуулахдаа дор дурдсан нөхцлийг хангасан байна.

А/ Худалдагч нь энэ хуульд заасны дагуу НӨАТатвар төлөгч байх»

НӨАТ-ын хуульд заасны дагуу аливаа этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон одроос хойш ажлын 10 өдрийн дотор бүртгүүлэх өргөдлөө харьяалагдах татварын албанд өгнө.

Монгол улсын СЭЗ-ийн сайдын 2002 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан «НӨАТ-ыг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд тусгах журам»-ын 2.2-т: «НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн аливаа этгээд НӨАТ төлөгчдөд борлуулсан бараа, ажил үйлчилгээндээ энэ журмын 2.1-д дурдсан НӨАТ-ын падааныг заавал 3 хувь бичиж, эх хувийг НӨАТ-ын ногдуулалт төлөлтийг тодорхойлохтой холбогдсон баримтын бүрдэл болгон өөртөө хадгалж, үлдэх 2, 3 дугаар хувийг худалдан авагчид олгоно. Худалдан авагч борлуулагчаас авсан НӨАТ-ын падааны 2-р хувийг тухайн сарын НӨАТ-ын тайланд хавсарган татварын албанд, 3 дугаар хувийг өөрийн үйл ажиллагааны санхүүгийн баримт болгон хадгална»

/2003 оны 148 тоот тушаалаар өөрчилсөн/



2. Худалдан авсан болон импортлосон бараанд төлсөн татвараа тэдгээрийн борлуулалтад ногдох татвараас хасах боломжийг татвар төлөгчдөд олгож байдаг. НӨАТ-ын хуулийн 11.1. «НӨАТ-ын хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлсэнээс хойшхи хугацаанд мөн хуулийн 5.6 дугаар зүйлд зааснаар ногдуулж төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно. 11.1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үйл ажиллагаанд зориулан бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн татвар. 11.1.2. Худалдах зориулалтаар болон үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үйл ажиллагаанд зориулан өөрөө шууд импортлосон бараа, ажил үйлчилгээнд төлсөн татвар. 11.2. Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг татварыг хасаж тооцохгүй».

3. Худалдан авсан болон импортлосон бараанд төлсөн татвараа тэдгээрийн борлуулалтад ногдох татвараас хасах эрхийг зөвхөн борлуулалтын орлого нь 10.0 сая төгрөгт хүрч, НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, ААНБ эдэлнэ. НӨАТ-ын хуулийн 3.1.9-д: «Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа үйлдвэрлэж, ажил, үйлчилгээ үзүүлэн орлого олж байгаа иргэн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрсэн өдрийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон өдөр гэнэ; мөн хуулийн 9.3-т: Жилийн 10 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ногдох борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг НӨАТ татвараас чөлөөлнө. Энэ заалт импортлогчдод хамаарахгүй». Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор буцааж олгоно. /2002-09-11-ний өдрийн хурлаар хэлэлцэж баталсан НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлэх аргачлалын 9.6-д/ Гэхдээ НӨАТ-ын хуулийн 11.4.3-т: «үйлдвэрлэгч-экспортлогчоос бусад татвар төлөгчийн татварыг төсвөөс улиралд нэг удаа буцааж олгоно» гэж заасан.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлсэнээс хойшхи тухайн нэг жилийн хугацааны татвар ногдох орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрээгүй нь аж ахуйн нэгж, байгууллагын хувьд санхүүгийн тайлангаар, иргэний хувьд орлого, татвар тодорхойлох хуудсаар нотлогдсон бөгөөд дараагийн жилүүдэд уг орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрэхгүй нөхцөлд харьяалах татварын алба нь түүнийг татвар төлөгчийн бүртгэлээс хасч, гэрчилгээг хураана. Татвар төлөгчийг бүртгэлээс хассан нь дахин бүртгүүлэхгүй байх үндэслэл болохгүй. (НӨАТ-ын хуулийн 4.8.)

Хөдөлмөрийн гэрээгээр байнга болон түр хугацаагаар ажил гүйцэтгэж буй иргэнийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч гэж тооцохгүй. (НӨАТ-ын хуулийн 4.6.)

“Борлуулалт” гэж барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэхийг хэлнэ. (НӨАТ-ын хуулийн 3.1.1.)



Албан татвар ногдуулах

НӨАТ-ын хуулийн 5 дугаар зүйл: Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил үйлчилгээ

5.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулна.

5.1.1. Монгол улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа

5.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хэрэглэх буюу ашиглах зориулалтаар экспортолсон бараа

5.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ

5.1.4. Монгол улсын нутаг дэвсгэрт худалдах, хэрэглэх буюу ашиглах зорилготой импортлосон бүх төрлийн бараа

5.2. Дор дурдсан үйл ажиллагааг “бараа борлуулсан” гэдэгт хамааруулна.

5.2.1. Эрхэлж буй аж ахуйн болон тодорхой бизнес эрхлэх эрхийг борлуулах

5.2.2. Татвар төлөгч нь үйлдвэрлэл, үйлчилгээгээ зогсоож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн бүртгэлээс хасагдах үед бизнесийн хөрөнгөөс өөрт үлдээсэн бараа, ажил, үйлчилгээ

5.2.3. Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу татварыг нь буцааж олгох аливаа бараа, ажил, үйлчилгээ

5.2.4. Бусад этгээдэд өрийн төлбөр болгон өгсөн бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ

5.3. Дор дурдсан үйл ажиллагааг “үйлчилгээ үзүүлсэн” гэдэгт хамааруулна.

5.3.1. Цахилгаан, дулаан, хий, ус хангамж, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ

5.3.2. Бараа түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах



- 5.3.3. Зочид буудал буюу түүнтэй адилтгах байранд байр түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах
- 5.3.4. Байшин барилгад байр түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах
- 5.3.5. Бараа хадгалах зориулалтаар байр түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах
- 5.3.6. Патент, зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, программ хангамж, хөрөнгийн бусад мэдээллийг худалдах, шилжүүлэх, түрээслүүлэх
- 5.3.7. Хонжворт тоглоом тоглуулах

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх

НӨАТ-ын хуулийн 9 дүгээр зүйлийн 1: Дараахь үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:

9.1.1. Санхүүгийн үйлчилгээ

- а) валют солих
- б) мөнгө хүлээн авах, шилжүүлэх, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гаргах, вексель, хадгаламжийн данстай холбогдсон банкны үйлчилгээ
- в) даатгал, давхар даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ
- г) үнэт цаас, хувьцаа гаргах, шилжүүлэх, хүлээн авах тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ
- д) урьдчилгаа, зээл олгох үйлчилгээ
- е) нийгмийн даатгалын сангийн хүүг олгох, шилжүүлэх үйлчилгээ
- ж) банкны хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамжийн үйлчилгээ



- 9.1.2. Орон сууцанд амьдран суух зориулалтаар байр түрээслүүлэх үйлчилгээ
- 9.1.3. Боловсролын үйлчилгээ
- 9.1.4. Эрүүл мэндийн үйлчилгээ: Энэ нь эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад хамаарахгүй
- 9.1.6. Шашны байгууллагын үйлчилгээ
- 9.1.7. Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ
- 9.1.8. Оршуулгын үйлчилгээ
- 9.1.10. Нийтийн үйлчилгээний авто тээврээр зорчигч тээвэрлэх үйлчилгээ
- 9.1.13. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын гадаадын жуулчдад үзүүлсэн үйлчилгээ
- 9.2. Дараахь **барааг** нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.
 - 9.2.1. Зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа
 - 9.2.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэрэгцээнд зориулан импортлосон бараа
 - 9.2.4. Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа



“Гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас хүмүүлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа” гэж давагдашигүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамигийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад зориулсан болон Монгол улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээний дагуу болон олон улсын тусламжийн байгууллагын шугамаар хариу төлбөргүй илгээсэн барааг, буцалтгүй болон хүмүүлэгийн тусламжийн хүрээнд гадаад улсын Засгийн газар, олон улсын болон буяны байгууллагаас өгсөн санхүүжилт /Монгол хөрөнгө/-ээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээ үүнд нэгэн адил хамаарна.

(НӨАТ-ын хуулийн 3.1.10)

- 9.2.7. Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл
- 9.2.11. Орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулах зориулалтаар шинээр барьж байгуулсан орон сууцны зориулалттай байр буюу түүний хэсэгт хамаарахгүй /Энэ заалт 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/.
- 9.2.14. Эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн /Энэ заалтыг 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/.
- 9.3. Жилийн 10 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ногдох борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. Энэ заалт импортлогчдод хамаарахгүй.



Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт

НӨАТ-ын хуулийн 11 дүгээр зүйл: **Худалдаж авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх**

- 11.1. НӨАТ-ын хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд мөн хуулийн 5,6 дугаар зүйлд зааснаар ногдуулж төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно.
- 11.1.1. Үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үйл ажиллагаанд зориулан бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн татвар
- 11.2. Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг татварыг хасаж тооцохгүй.
- 11.3. Дараахь бараа, үйлчилгээг импортлох, худалдаж авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг худалдан авагчийн төлөх уг татварын нийт дүнгээс хасахгүй.
- 11.3.1. Суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг
- 11.3.2. Хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, үйлчилгээ
- 11.3.4. Энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6, 9.1.10, 9.1.13, 9.2.15-д заасан үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортлосон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ



- 11.4. Энэ хуулийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу татвар төлөгчид тухайн сард хасалт хийх татварын хэмжээ нь түүний мөн хугацаанд төлбөл зохих уг татварын дүнгээс их байвал татварын алба дараахь байдлаар зохицуулна.
- 11.4.1. Дараагийн сар, улирал, жилд төлөх нэмэгдсэн өртгийн албан татварт тооцох
- 11.4.2. Хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт орох бусад төрлийн татварын өрөнд тооцох
- 11.4.3. Төсвөөс буцааж олгох
- 11.5. Татварын албан татвар төлөгчийн төсөвт илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар, гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын төсөвт төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн байгууллага татварын албатай тооцоо хийснээс 15 өдрийн дотор хянаж баталгаажуулсан төсвөөс буцаан олгуулах асуудлыг санхүү, эдийн засгийн агуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 11.6. Татвар төлөгчдийн илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох зориулалт бүхий тусгай сантай байна. Тусгай сан нь Санхүү, эдийн засгийн агуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний мэдэлд байна.

Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор буцааж олгоно.



Нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэл

**“Нэмэгдсэн өртгийн албан татварыг анхан шатны болон нягтлан бодох бүртгэл,
тайланд тусгах журам”-аас:**

- 2.1. НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн аливаа хуулийн этгээд бараа, ажил, үйлчилгээг борлуулахдаа НӨАТ-ын баримт /НӨАТ-ын падаан/-ыг бичих бөгөөд уг баримтад бараа, ажил, үйлчилгээний нэр, зэрэг, дугаар, хэмжих нэгж, тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон бүгд үнийг тусгана. Борлуулсан бараа, ажил үйлчилгээ тус бүрийн үнийг гаргасны дараа НӨАТ-ыг үнийн дүнгийн 15 хувиар бодон тусад нь бичин, түүнийг бараа, ажил, үйлчилгээний үнэ дээр нэмж нэхэмжлэх төлбөрийн нийт хэмжээг тодорхойлно.
- 2.2. НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн аливаа этгээд НӨАТ төлөгчдөд борлуулсан бараа ажил, үйлчилгээндээ энэ журмын 2.1-д дурдсан НӨАТ-ын падааныг заавал 3 хувь бичиж, эх хувийг НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг тодорхойлохтой холбогдсон баримтын бүрдэл болгон өөртөө хадгалж, үлдэх 2, 3 дугаар хувийг худалдан авагчид олгоно. Худалдан авагч борлуулагчаас авсан НӨАТ-ын падааны 2 дугаар хувийг тухайн сарын НӨАТ-ын тайланд хавсарган татварын албанд, 3 дугаар хувийг өөрийн үйл ажиллагааны санхүүгийн баримт болгон хадгална.
- 2.3. НӨАТ төлөгчдөөс бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан НӨАТ төлөгч аливаа этгээд нь худалдан авсан бараа, ажил, үйлчилгээндээ энэ журмын 2.1-д дурдсан баримтыг заавал бичүүлж авах бөгөөд уг баримтын дагуу худалдан авалтын дэвтрийг хөтөлж, тухайн тайлангийн хугацаанд хасагдах НӨАТ-ын хэмжээг тодорхойлно. НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн борлуулагчийн бичсэн НӨАТ-ын баримтгүй тохиолдолд хасалт хийхгүй.



Санамж

Татвар төлөх, тайлагнах

Татвар төлөгч нь тухайн сард бордуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг дараа сарын 10-ны дотор төсөвт төлж, тайлангаа татварын албанд тушаана.

БОДЛОГО 1



1. Нэгэн ТББ өөрийн эзэмшлийн 300 ам метр талбай бүхий байрныхаа 200 ам метр талбайг өөр байгууллагуудад түрээслэж 1 ам метрийг нь 10,000 төгрөгөөр бодож түрээсийн төлбөр авдаг бол татварыг хэрхэн тооцох вэ?

Хариу:



- $200 \text{ ам метр} \times 10.000 = 2.000.000$ төгрөгийн түрээсийн орлого сард олдог байна. /хэрэв түрээсийн төлбөрийг доллараар авдаг бол тухайн өдрийн Монгол банкны ханшаар бодно/
- Энэ ТББ нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн /жилийн орлого 10 сая төгрөгөөс дээш/ тул түрээслэгчдээс НӨАТ-ыг нэмж нэхэмжлэн авна.
- $\text{НӨАТ} = 2.000.000 \times 15\% = 300.000$
- Түрээслүүлэгчдээс нийт нэхэмжлэн авах
 $\text{дүн} = \text{түрээс} + \text{НӨАТ} = 2.000.000 + 300.000 = 2.300.000$ төгрөг болно.

БОДЛОГО 2

“А” ТББ нь сар бүр Монголын цахилгаан холбоо болон Мэжикнет компаниудад утас болон интернет ашигласны төлбөр болох 110.000 төгрөг төлдөг. Утасны төлбөр болох 80.000 төгрөг дээр 15% НӨАТ-ийн 12.000 төгрөг, Интернетийн төлбөр 30.000 төгрөг дээр НӨАТ-ын 4.500 төгрөг тушаадаг бол тус ТББ нь НӨАТ-ын хасалтад хамрагдаж НӨАТ-аа хэрхэн буцааж авах вэ?

Хариу:

«А» ТББ нь НӨАТ төлөгч биш байх тул (жилийн борлуулалтын орлого нь 10 сая төгрөгт хүрэхгүй) эдгээр аж ахуйн нэгжүүдэд төлсөн НӨАТ-ын хасалтыг хийх эрхгүй. Иймд бусдад төлсөн НӨАТ-аа зардалд бичнэ. Тодруулбал, НӨАТ-ын хасалтын тухай асуудал яригдахгүй гэсэн үг.

БОДЛОГО 3


«А» ТББ нь НӨАТ төлөгч бөгөөд энэ сард 3,800.000 төгрөгийн борлуулалт хийсэн. Монголын Цахилгаан Холбоо болон Мэжикнет компаниудад утас болон интернет ашигласны төлбөр болох 210.000 төгрөгийг НӨА татвар 31.500 төгрөгийн хамт төлсөн, 273.300 төгрөгийн бичиг хэргийн материалыг 40.995 төгрөгийн НӨАТ-тайгаар худалдан авч төлбөрийг бэлнээр төлсөн, 3,201.000 төгрөгийн канон, компьютерийг импортоор оруулж ирж гаальд 160.050 төгрөгийн гаалийн татвар, 504.157 төгрөгийн НӨАТ төлсөн бол энэ сарын НӨАТ-ын тооцоог хийнэ үү?

**Хариу:**

- Тухайн сарын борлуулалтын орлого 3.800.000 төгрөг. Ногдуулсан НӨАТ нь $3.800.000 * 15\% = 570.000$ төгрөг
- Тухайн сарын худалдан авсан бараа ажил үйлчилгээнд төлсөн НӨАТ= $31.500+40.995+504.157=576652$ төгрөг
- Тухайн сард төсөвт төлбөл зохих НӨАТ=Борлуулалтанд ногдох НӨАТ - худалдан авалтанд ногдох НӨАТ = $570.000 - 576652 = - 6652$ төгрөгийн НӨА татварыг төсвөөс буцаан авна.

**Тайлбар:**

- Борлуулалтад ногдох НӨАТ гэдэг нь тухайн сард хийгдсэн борлуулалтын дүнд ногдуулж нэхэмжилж авсан НӨАТ юм.
- (НӨАТ-ын падаан дээр барааны үнэ 300.000 төгрөг, НӨАТ 45.000, бүгд 345.000 төгрөг гэж бичдэг. Үүнээс 300.000 төгрөг нь барааны борлуулалтын дүн, 45.000 нь борлуулалтад ногдуулсан НӨАТ юм)
- Худалдан авалтанд ногдох НӨАТ гэдэг нь худалдан авсан бараа ажил үйлчилгээнд төлсөн НӨАТ юм. (Жишээ нь: МЦХК-ийн нэхэмжлэл, НӨАТ-ын падаан дээр утасны төлбөр 80.000 төгрөг, НӨАТ- 12.000 төгрөг, бүгд 92.000 төгрөг гэж бичсэн байдаг. Үүнээс 80.000 төгрөг нь худалдан авалтын үнэ, хөлс; 12.000 төгрөг нь худалдан авалтад төлсөн НӨАТ юм)



У БУЛГА

Гаалийн албан татвар





Гаалийн албан татвар

Монгол Улсын Гаалийн тарифын тухай хууль нь 1996 оны 5-р сарын 20-ны өдөр батлагджээ.

Барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тарифын тухай хууль болон Гаалийн тухай хуулийн дагуу гаалийн байгууллагын хурааж авах албан татварыг гаалийн татвар гэнэ

Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

Гаалийн албан татвараас чөлөөлөх асуудлыг гагцхүү Гаалийн тарифын тухай (ГТ) хуулиар зохицуулна.

Дор дурдсан барааг гаалийн татвараас чөлөөлнө:

- тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, материал, түүхий эд
- хүмүүнлэг, буцалтгүй тусламжийн бараа
- зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс
- эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн болон тэдгээрийн тохироог баталгаажуулах, чанарыг алдагдуулахгүй хадгалах, тээвэрлэхэд шаардагдах оношлуур, урвалж, багаж, хэрэгсэл, сав, баглаа боодол

(ГТ-ын хуулийн 6 дугаар бүлэг, 21-р зүйлийн 1)

Тодруулга

§ “Хүмүүнлэг тусламжийн бараа” гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах өөр бусад гамшигийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад зориулж илгээсэн барааг хэлнэ.

§ “Буцалтгүй тусламжийн бараа” гэж МУ-ын олон улсын гэрээний дагуу хариу төлбөргүй илгээж буй барааг хэлнэ.

Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ

Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг Монгол Улсын Их хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27-р тогтоолоор батлагдсан болно.

БОДЛОГО 1

Боловсролын чиглэлээр ажилладаг нэгэн ТББ Япон улсын хүмүүнлэгийн сангаас 500 ам. долларын өртөг бүхий ном товхимлыг бэлгэнд авах болжээ. Энэ байгууллага номоо гаалиар оруулж ирэхийн тулд ямар татвар төлөх вэ?

Хариу:

- Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлд: «21.1. Дор дурдсан барааг гаалийн татвараас чөлөөлнө. 21.1.5. хүмүүнлэг, буцалтгүй тусламжийн бараа», 3.1.1. «хүмүүнлэг тусламжийн бараа гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах өөр бусад гамшигийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад



- зориулж илгээсэн барааг хэлнэ. 3.1.2. буцалтгүй тусламжийн бараа гэж Монгол улсын олон улсын гэрээний дагуу хариу төлбөргүй илгээж буй барааг хэлнэ»;
- НӨАТатварын хуулийн 9 дүгээр зүйлд: «9.1. Энэ хуулийн хүрээнд дараахүйлчилгээг НӨАТатвараас чөлөөлнө. 9.2.4. гадаад улсын засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа. 3.1.10. гадаад улсын засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад зориулсан болон Монгол улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан Монгол улсын олон улсын гэрээний дагуу болон олон улсын тусламжийн байгууллагын шугамаар хариу төлбөргүй илгээж буй барааг хэлнэ» гэж заасан байна.
 - Хэрэв энэ бэлгийг Монгол улсын олон улсын гэрээний хуулийн хүрээнд оруулж ирсэн бол Монгол улсын олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлд: «Заавал соёрхон батлах гэрээнд дараахь олон улсын гэрээ багтана. 10.1. Монгол улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээ»; мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т: «Засгийн газар олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг хэлэлцээд зохих шийдвэр гарган Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ»; мөн хуулийн 12 дугаар зүйлийн 2-т: «Монгол Улсын Их Хурал олон улсын гэрээг соёрхон батлавал хууль, соёрхон батлаагүй тохиолдолд тогтоол тус тус гаргана»

Дээрх нөхцөл бүрдсэн тохиолдолд татваргүйгээр оруулж ирэх боломжтой.

- Харин манай жишээн дээр 500\$ -ын дээрх бараа нь гааль, НӨАТатвараас чөлөөлөгдөх боломжгүй байх тул гаалийн байгууллага гаалийн болон НӨАТатварыг ногдуулан төлүүлнэ.
 - гаалийн үнэ=500\$ x Мбанкны ханш=500\$ x 1170=585000 төгрөг
 - гаалийн татвар=гаалийн үнэ x 5% = 585000 x 5% =29250 төгрөг
 - НӨАТатвар тооцох үнэлгээ = гаалийн үнэ +гаалийн татвар =585000 +29250 = 614250 төгрөг
 - НӨАТ = 614250 x 15% = 92135.50 төгрөг
 - Нийт төлөх татварын дүн= гаалийн татвар+НӨАТ = 29250+ +92135.50 = 121387.50 төгрөг болно



III бүлэг

*Авто тээврийн
болон өөрөө явагч
хэрэгслийн албан татвар*





Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль нь 1992 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдаж, 1997.04.24, 1997.07.03, 1998.01.09, 2000.11.16, 2003 оны 12 дугаар сарын 26-нд нэмэлт, өөрчлөлт орсон.

Улсын бүртгэлд байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл бүхий иргэн, хуулийн этгээдэд ногдуулж буй албан татварыг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар гэнэ.

Албан татвар төлөгч

Монгол улсын нутаг дэвсгэрт авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **албан татвар төлөгч** байна. (Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 3 дугаар зүйл)

Улсын бүртгэлд байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийн ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна.

Улсын бүртгэл гэдэг нь замын цагдаагийн байгууллагын нэгдсэн бүртгэлд орж дугаар авч, өмчлөгч болсон байхыг хэлнэ.



Албан татвар ногдох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл

Албан татвар ногдох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд дараахь төрлийн автомашин, өөрөө явагч хэрэгсэл орно. Үүнд:

- Бүх төрлийн ачааны автомашин
- Автобус
- Бүх төрлийн суудлын автомашин
- Мотоцикл
- Тусгай зориулалтын автомашин. Тухайлбал: Кран, засвар үйлчилгээний болон лабораторийн зориулалттай тоноглогдсон машин
- Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл
- Авто чиргүүл (энэ заалтыг 1998 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн).

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь, хэмжээ

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараахь хэмжээгээр ногдуулна.

(Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 5 дугаар зүйл)



Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Жилд ногдуулах албан татвар /төгрөгөөр/	
	УБ, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд	Бусад бүх сум
1. 2 дугуйтай мотоцикл	2000	1800
2. 3 дугуйтай мотоцикл	3000	2800
3. Суудлын автомашин:	/Цилиндрийн багтаамжийн нэг см куб тутамд төгрөгөөр/	
а/ 2000 см куб хүртэл	16	14
б/ 2001-3000 см куб	18	16
в/ 3001 см куб-ээс дээш	22	20
4. Микроавтобус /15 хүртэл хүний суудалтай/	35000	28000
5. Автобус	52000	40000
6. Ачааны автомашин а/ 1 хүртэл тн-ын даацтай	25000	20000
б/ 1-2 тн-ын даацтай	35000	28000
в/ 2-3 тн-ын даацтай	45000	36000
г/ 3-5 тн-ын даацтай	55000	44000
д/ 5-8 тн-ын даацтай	80000	64000
е/ 8-10 тн-ын даацтай	90000	72000
ж/ 10 тн-оос дээш даацтай	100000	80000
7.Тусгай зориулалтын автомашин	16000	15000
8. Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	14000	11200
9. Бага оврын трактор	7000	5600
10. Чиргүүл /даацын тн тутамд/	5500	5500

Санамж

Иргэн нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлнө. Хэрэв 6 дугаар сарын 1-нээс хойш авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг импортоор оруулж ирсэн бол харьяалах татварын албанд тухайн жилдээ багтаан үлдсэн хугацаанд ногдох татварыг төлнө. Аж ахуйн нэгж, байгууллага жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор төлж, дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг гаргаж тушаана.

“Дипломатын харилцааны тухай” 1961 оны, “Консулын харилцааны тухай” 1965 оны Венийн конвенцийн дагуу гадаадын Дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс албан татвар авдаггүй.

БОДЛОГО 1

Хот, хөдөөд салбартай нэгэн ТББ өөрийн албан хэрэгцээнд УАЗ-31512 машин, Мицубиши Пажеро 3.5-GDI-V6-WAGON маркийн 2 автомашинтай. Татварыг хэрхэн тооцох вэ? Хөдөө орон нутаг, Улаабаатар хотын автомашины татвар ижил төлөгдөх үү?

Хариу:

нэр/төрөл		УБ хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд	Бусад бүх сумд
УАЗ-31512 машин мицубиши пажеро	2445 см.куб	2445 х 18төг=44010	2445х16төг=39120
3.5 GDI V6 Wagon	3497 см.куб	3497х22төг=76934	3497х20төг=69940
Төлөх татварын дүн		120944	109060



БОДЛОГО 2



Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нэгэн олон улсын байгууллага нь өөрийн хэрэгцээнд 5 жил явсан TOYOTA Марк II 2.4 D маркийн жип автомашинаа УБ хотод бүртгэлтэй “А” ТББ-д 3 дугаар сард бэлэглэж өмчлөх эрхээ шилжүүлсэн. Тус автомашины үлдэгдэл үнэ нь 4.500 ам. доллар байсан гэж тооцвол уг ТББ ямар татвар төлөх вэ?

Хариу:



- TOYOTA Марк II 2.4 D маркийн жип автомашины цилиндрийн багтаамж 2446 см.куб байна.
- Жилд төлөх татвар /УБ хотод/ $2446 \times 18 \text{ төг} = 44.028 \text{ төгрөг}$ ногдоно.
/сард төлөх татвар $44028 : 12 = 3669 \text{ төгрөг}$.
- Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2-г: “Албан татвар төлөгч авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд түүний албан татвар төлөх үүрэг дараа улирлаас эхлэн дуусгавар болно” гэж заасан.
“А” ТББ-ын уг машиныг эзэмшсэн хугацаанд /9 сар/ төлөх татвар
- $3669 \text{ төг} \times 9 = 33.021 \text{ төгрөг}$ төлнө.

БОДЛОГО 3



“Б” ТББ нь нэг микро автобустай бөгөөд эвдэрсэн тул ашиглахгүй байгаа. Иймд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг төлөхгүй байж болох уу?

Хариу:



- Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1-д: «Улсын бүртгэлд байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсхийг үл харгалзан албан татвар ногдуулна» гэж заасныг үндэслэн ногдох татварыг төлнө.
- Микроавтобус УБ хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд 35.000 төгрөг, бусад бүх сумд 28.000 төгрөг төлнө.



III бүлэг

*Үл хөдлөх
эд хөрөнгийн
албан татвар*





Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж, 2002 оны 7 дугаар сарын 4, 2003 оны 1 дүгээр сарын 2, 2004 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиудаар өөрчлөлт орсон.

Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсад ногдуулж буй албан татварыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар гэнэ.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч

4.1. МУ-ын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна.

4.1.1 өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар

4.1.2 төрийн бус байгууллага, сан, шашны байгууллага

4.1.3 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

4.1.4 МУ-ын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн

4.1.5 МУ-д оршин суугч бус этгээд

(Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйл)



Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээ, хувь хэмжээ

Хуулийн 5 дугаар зүйлийн 1-д: «Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг:

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр
2. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр
3. Хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлохоор хуульчлагдсан байна».

Хуулийн 6 дугаар зүйлд: «Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг ногдуулахдаа дээрхи үнэлгээний 0,6 хувиар тооцож ногдуулна».

БОДЛОГО 1



«М» ТББ нь 30 сая төгрөгийн үнэлгээ бүхий барилгатай. Хэдэн төгрөгийн татвар төлөх вэ?

Хариу:



Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6-р зүйлд: «энэ хуулийн 5-р зүйлд заасан үнэлгээнээс 0,6 хувиар тооцож ногдуулна» гэснийг үндэслэн жилд $30.000.000 \times 0,6\% = 180.000$ төгрөг төлнө.



Үл хөдлөх эд хөрөнгийн татвараас чөлөөлөх

Хуульд зааснаар дараахь үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлнө.

1. Төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө
1. Орон сууц
2. Нийтийн эзэмшлийн барилга байгууламж

Санамж

Татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгөндөө жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар байгаа үнэлгээндээ тулгуурлан татвар ногдуулна. Ногдуулсан татвараа улирал бүрийн сүүлчийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож тухайн орон нутгийн төсөвт төлнө.

Татвар төлөгч нь татварын тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харъяалагдах татварын албанд тушаана.



VIII бүлэг

*Бууны
албан
татвар*

БУУНЫ АЛБАН ТАТВАР





Бууны албан татвар

Монгол Улсын Бууны албан татварын тухай хууль 1993 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж, 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон.

Монгол улсын нутаг дэвсгэрт буу эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдэд ногдуулдаг татварыг бууны албан татвар гэнэ.

Татвар төлөгч

Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжид заасан журмын дагуу буу эзэмшиж байгаа:

- Монгол Улсын иргэн
- Өмчийн бүх төрөлд хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага
- Монгол Улсын нутаг дэвсгэрт буу эзэмшигч гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд, харьяалалгүй хүмүүс/ олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол/ татвар төлөгч болно.



Буу эзэмшигч албан татвар төлөгчийн үүрэг

1. Өөрийн өмч эзэмшилд байгаа бууг тухайн эзэмшигч нь жил бүрийн 12 дугаар сард цагдаагийн байгууллагад бүртгүүлж, албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон бууг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах
2. Бууг өвлөх, худалдан авах, бэлэг дурсгалд авах зэргээр өмчлөх болсон тохиолдолд тухайн бууг эзэмшилдээ авснаас хойш 30 хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж үнэмлэх авах
3. Албан татвар төлөгч хэрэв шилжин өөр газарт суурьшвал буугаа оршин сууж байсан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүртгэлээс хасуулан татварын тооцоо хийж байх, очсон газраа мөн 30 хоногт багтаан бүртгүүлэх үүрэгтэй.

Татвар ногдох буу:

Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, цагдаагийн болон ял эдлүүлэх байгууллагын бие бүрэлдэхүүний зэвсэглэлийн зориулалтаар ашиглаж байгаагаас бусад бүх буунд албан татвар ногдоно.



Татвар ногдох буу, татварын хувь хэмжээ

Татвар ногдох буу бүрт татварыг жилээр хатуу тогтоосон хэмжээгээр ногдуулан төлнө.

Ногдох татвар хэмжээ:

- Үрлэн сумтай буу – 4.000 төгрөг
- 6,4 мм хүртэлх калибрийн бүх төрлийн буу – 4.000 төгрөг
- 6,5 ба түүнээс дээш мм-ийн калибрын бүх төрлийн буу – 6.000 төгрөг

Албан татвараас чөлөөлөх

1. Дараах бууг албан татвараас чөлөөлнө:
 - музейн үзмэр, урлагийн тоглолтод ашиглагдаж байгаа болон ангийн зориулалтаар ашиглах боломжгүй болохыг цагдаагийн байгууллага тогтоож үнэмлэх олгосон,
 - байгаль хамгаалагчийн эзэмшилд байгаа албаны буу
 - спорт, сургалтын зориулалтаар дагнан ашиглаж байгаа
2. Хөдөлмөрийн чадваргүй болон албан татвар төлөх орлогогүй иргэнийг харъяалах сум, дүүргийн татварын алба тухайн жилийн албан татвараас чөлөөлж болно.

(Бууны албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл)



IX бүлэг

Төлбөр хураамж





1. Газрын төлбөр

Газрын төлбөрийн тухай хууль 1997 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан.

Газрын төлбөр төлөгч

Газрын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээ байгуулан газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна.

(Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйл)

Төлбөр ногдуулах газар

Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа, Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна.

(Газрын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйл)

Санамж

Газрын төлбөр ногдуулах

Газрын төлбөр төлөгч нь газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд өөрөөр заагаагүй бол жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирал бүрийн эхний сарын 25-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

(Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйл)



Газрын төлбөрийг төлөх, тайлагнах

1. Газрын төлбөрийн орлогыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт оруулна.
2. Газрын төлбөрийн орлогын зохих хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан зарцуулна. Тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, газрын төлбөрөөс орох орлогыг харгалзан газар хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зориулан зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг засгийн газар жил бүр тогтооно.
3. Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ болон газрын төлбөрийн тухайн шатны тайлангийн нэг хувийг татварын албанд тушаана.
4. Татварын алба татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

(Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйл).

Хариуцлага

Газрын төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагыг татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заасантай нийцүүлэн газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай гэрээнд тусгана.

(Газрын төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйл).



2. Улсын тэмдэгтийн хураамж

Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хууль 1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр батлагдсанаас хойш 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Улсын тэмдэгтийн хураамж

Төрийн зохих байгууллагаас эрх олгох, эрх шилжихтэй холбогдсон баримт бичиг олгох буюу бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлан гэрчлэх, иргэний бүртгэл хийх, шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг *улсын тэмдэгтийн хураамж* гэнэ.

(Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3-р зүйл)

Хураамж төлөгч

Энэ хуульд заасан хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон аж ахуйн нэгж, байгууллага нь хураамж төлөгч байна.

(Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл)



Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрлүүд

Тэмдэгтийн хураамжийг төрийн байгууллагын үзүүлж байгаа дараахь үйлчилгээнээс хураах бөгөөд төрийн бус байгууллага эдгээр үйлчилгээг авч байгаа бол тэмдэгтийн хураамж төлөгч байна.

1. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх
2. Нотариатын үйлчилгээ үзүүлэх
3. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хийх, паспорт, зөвшөөрөл, виз олгох
4. Консулын үйлчилгээ үзүүлэх /гадаад паспорт, буцах үнэмлэх олгох, гадаадын иргэнд виз олгох/
5. Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгох
6. Буу бүртгэх
7. Сонин сэтгүүл бүртгэх
8. Аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх
9. Гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгох
10. Тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгох
11. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэх
12. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэх
13. Үнэт цаасны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, бүртгэх. Эдгээр үйлчилгээний тэмдэгтийн хураамжийг хатуу тогтоосон хэмжээгээр ногдуулна.
14. Хуулиар хураамж төлөхөөр заасан бусад үйлчилгээ

(Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйл)



Тэмдэгтийн хураамж, хураамжийн хэмжээ

А. Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах хураамжийн хэмжээ

Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана.

(Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйл)

1. Эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд:

Нэхэмжлэлийн үнэ, төгрөгөөр	Хураамжийн хэмжээ
0 - 3.000	50 төгрөг
3.001 - 10.000	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2 хувь
10.001 - 50.000	200 төгрөг дээр 10000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3,5 хувийг нэмнэ.
50.001 - 500.000	1500 төгрөг дээр 50000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4 хувийг нэмнэ.
500.001 - 1,000.000	19500 төгрөг дээр 500000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2,1 хувийг нэмнэ.
1,000.001 - 10,000.000	30000 төгрөг дээр 1000000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 1,4 хувийг нэмнэ.
10,000.001- ээс дээш	156000 төгрөг дээр 10000000-аас дээш төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0,5 хувийг нэмнэ.



2. Эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 250 төгрөг
3. Хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутмаас 25 төгрөг

Б. Нотариатын үйлчилгээний хураамж


1. Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээний хураамж хураана:

1. Эд хөрөнгийн бус, үнэлж болохгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 500 төгрөг
2. Эд хөрөнгийн бус, үнэлж болохгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 500 төгрөг
3. Эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, хэлцэл гэрчлэхэд 750 төгрөг
4. Хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг гэрчлэхэд 2000 төгрөг
5. Хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 500 төгрөг
6. Итгэмжлэл гэрчлэхэд 500 төгрөг
7. Бичиг баримтыг гэрчлэхэд хуудас тутмаас 50 төгрөг
8. Орчуулсан бичиг баримтыг гэрчлэхэд хуудас тутмаас 100 төгрөг
9. Бичиг баримтад зурсан гарын үсгийг гэрчлэхэд 1000 төгрөг
10. Гэрчлэгдсэн бичиг баримтын хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 50 төгрөг



11. Үйлчлүүлэгчдийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 2000 төгрөг
12. Өв залгамжлах эрх, гэрээслэлийг гэрчлэхэд 500 төгрөг
13. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 250 төгрөг
14. Үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой бичиг баримт гэрчлэхэд 2000 төгрөг
15. Өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүмүүст өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 4000 төгрөг
16. Үл хөдлөх хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхэд гэрээний үнийн дүнгээс 0,03 хувь, бусад хүмүүст 0,05 хувь
17. Энэ хэсгийн 1,2,3,16-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 сая хүртэлх төгрөгөөс 0,02 хувь, 1 сая төгрөгөөс давсан хэсгээс 0,01 хувь

(Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйл)



Х Б У А Г

*ТББ-ын
татвартай
холбоотой
нийтлэг асуултууд*





ТББ-ЫН ТАТВАРТАЙ ХОЛБООТОЙ НИЙТЛЭГ АСУУЛТУУД

Татвар төлөгч гэж хэн бэ?

Хуулийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, тодорхой эрх бүхий эсхүл эд хөрөнгө эзэмшин ашиглаж байгаа дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөгч байна.

1. Монгол улсын иргэн
2. Тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд
3. Тус улсын нутаг дэвсгэрт оршин байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, сан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байрладаггүй боловч тус улсад орлого олж байгаа хуулийн этгээд
4. Тус улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар

Татвар төлөгчийг хэрхэн бүртгэх вэ?

1. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага татварын албанд бүртгүүлнэ.
2. Татвар төлөгч иргэнийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно.

Татвар төлөгчийн үүрэгт юу ордог вэ?

Татвар төлөгч дараахь үүрэг хүлээнэ:

1. Татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх
2. Татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх
3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах
4. Татварын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар татварын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх
5. Татварын албаны шалгалтын актыг зөвшөөрч байгаа бол гарын үсэг зурах. Актыг зөвшөөрөхгүй тохиолдолд тайлбараа бичгээр гаргаж өгнө.

3. Татвар төлөгчийн үүрэгт юу ордог вэ?

6. Аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх
7. Татварын хуульд тусгайлан татвар ногдуулахаар заасан орлогод татвар ногдуулж, хуульд заасан хугацаанд төсөвт төлөх
8. Хуулиар хориглоогүй үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх
9. Аж ахуйн нэгж, байгууллага нь дундын суутгал хийсэн татварын ногдуулалт, төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, хаяг, регистрээр улирал тутам гаргаж өөрийн харьяалагдах татварын албанд өгөх
10. Татвар ногдох эд хөрөнгө, эрхээ бусдын өмчлөлд шилжүүлсэн тухай баримтыг татварын албанд гаргаж өгөх
11. Өөрийн нэр, хаяг, тамга, тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, харилцах болон хувийн дансыг бусдад ашиглуулан татвараас зайлсхийх боломж олгохгүй байх
12. Эрх бүхий байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээсэлсэн, худалдсан тохиолдолд харьяалагдах татварын албанд мэдэгдэх
13. Банкинд данс нээсэн болон түүнийг хаасан бол энэ тухай харьяалагдах татварын албанд мэдэгдэх
14. Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газраас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлал, зөвлөмжийг дагаж мөрдөх
15. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг зэрэг орно.

4. Татвар төлөгчийн эрхэд юу орох вэ?

Татвар төлөгч дараахь эрх эдэлнэ:

1. Татварын хууль тогтоомжид заасан нөхцөлд хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх. Хэд хэдэн нөхцлөөр хөнгөлөлт эдлэх тохиолдолд аль нэгийг нь сонгон авах
2. Татварын албаны шалгалтын акттай танилцах
3. Татварын ногдуулалт, төлөлт, шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх



Татвар төлөгчийн эрхэд юу орох вэ?

4. Татварын албаны буруугаар учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх
5. Илүү төлсөн татварыг эгүүлэн авах буюу суутган тооцуулах
6. Татварын алба, түүний байцаагчийн хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлоо эрх бүхий төрийн захиргааны байгууллага болон шүүхэд хууль тогтоомжийн дагуу гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй. Харин уг гомдлыг хянаж байгаа шүүхийн шийдвэрээр татвар төлөхийг түр зогсоож болно.

Албан татвар, төлбөр, хураамжийн ялгаа юу вэ?

Монгол улсын татварын тогтолцоо нь:

1. Албан татвар
2. Төлбөр
3. Хураамжаас бүрддэг.

Албан татвар нь хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж хариу төлбөргүйгээр улс орон нутгийн төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө юм.

Монгол улсад одоогийн байдлаар дараах албан татварын хуулиуд мөрдөгдөж байна.

Үүнд:

1. Хүн амын орлогын албан татвар
2. Аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар
3. Гаалийн албан татвар
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар
5. Онцгой албан татвар

6. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
7. Бууны албан татвар
8. Авто бензин, дизелийн түлшний албан татвар
9. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Төлбөр нь төрийн өмч /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой усны нөөц зэрэг/ ашигласны төлөө иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас авч, улс орон нутгийн төсөв тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө юм.

1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай
2. Газрын төлбөр
3. Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай
4. Агнуурын нөөц ашигласны төлбөрийн тухай
5. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн тухай
6. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай, байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулиудын үндсэн дээр төлбөр авч байна.

Хураамж нь хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө гэднээс тухай бүр авч улс орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө юм. Төсөвт:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай
2. Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн тухай хуулиар хураамж авч байна.

Улсын болон орон нутгийн татвар гэж юу вэ?

Монгол улсын татвар нь улсын болон орон нутгийн татвараас бүрдэнэ.

1. Улсын Их Хурал, Засгийн газраас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх татварыг улсын татвар гэнэ.
2. Аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварыг орон нутгийн татвар гэнэ.



Улсын татварт татварын ямар төрлүүд хамаарах вэ?

Улсын татварт дараахь татвар хамаарна:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар
2. Гаалийн албан татвар
3. Нэмэгдсэн өртгийн албан татвар
4. Онцгой албан татвар
5. Авто бензин, дизелийн түлшний албан татвар
6. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
7. Хүн амын орлогын албан татвар
8. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар

Орон нутгийн татварт татварын ямар төрлүүд хамаарах вэ?

Орон нутгийн татварт дараахь татвар хамаарна:

1. Бууны албан татвар
2. Нийслэл хотын албан татвар
3. Нохойны албан татвар
4. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар
5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
6. Улсын тэмдэгтийн хураамж
7. Ус, рашаан ашигласны төлбөр
8. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
9. Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж
10. Байгалийн ургамал ашигласны төлбөр
11. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
12. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж
13. Газрын төлбөр
14. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр

Ямар тохиолдолд татвар төлөх үүрэг дуусгавар болох вэ?

Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар татвар төлөх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болдог. Үүнд:

1. Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон
2. Тухайн төрлийн татвар төлж дууссан
3. Татвар төлөгч тухайн төрлийн татвараас бүрэн чөлөөлөгдсөн
4. Татвар төлөгч нас барсан, нас барсанд тооцогдсон
5. Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан.

Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу санаатайгаар бууруулсан гэж юуг хэлэх вэ? Тайлбарлана уу.**Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан гэж:**

- Орлого, орлогоос бусад зүйлийг биетээр нуун дарагдуулах
- Үндэслэлгүйгээр бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх
- Нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулах
- Нягтлан бодох бүртгэл, татварын тайланд санаатайгаар буруу бичилт хийх
- Хууль бус хэлцэл хийж, хууран мэхлэх
- Холбогдох баримт бичгийг гаргаж өгөхгүй байх
- Хуурамчаар өглөг үүсгэх
- Татвар төлөхгүйн тулд баримт бичгийг хуурамчаар үйлдэх
- ААНБ-ынхаа нэр, хаяг, тамга, тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөл болон эд хөрөнгө, иргэний бичиг баримтаа бусад ашиглуулах замаар татвараас зайлсхийх боломж олгосон зэрэг үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг санаатайгаар бууруулсан гэж:

- Татвар ногдох орлогоос бусад зүйлийн тоо хэмжээ, үнийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, тайлан, мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд санаатай багасган тусгах
- Орлогоо багасгаж харуулахын тулд засварлах замаар хуурамч баримт бичиг үйлдэх
- Зардлаа хуурамчаар өсгөх
- Орлогоо зохиомлоор багасгах зэрэг үйлдлийг ойлгоно.



Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан гэж юуг хэлэх вэ?

Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан гэж:

- Уг зүйлийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны үйлдэл алдах
- Нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтөлж, тайлан тэнцлээ зөв гаргасан боловч татвар ногдох орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүнг буруу тодорхойлсон үйлдлийг хэлнэ.

Хүчингүй гэрээ, хэлцэл гэж ямар гэрээг хэлэх вэ?

Хүчингүй гэрээ, хэлцэл гэж:

- Утга агуулгаараа хууль зөрчсөн буюу хуулиас гадуур хийгдсэн
- Бага насны хүмүүс, сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио зэрэг шалтгааны улмаас эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдтэй хийсэн хэлцэл
- Айлган сүрдүүлэх буюу аргагүй гачигдлыг далимдуулан хийсэн хэлцэл
- Хууль ёсны үр дүн гаргахын тулд биш зөвхөн дүр үзүүлэн хийсэн хэлцлийг хэлнэ.

Татвар төлөгчийг татвараас чөлөөлөх ямар хэлбэр байдаг вэ?

1. Тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээг татвараас чөлөөлөх
2. Татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх
3. Татвар төлөгчийг татвараас чөлөөлөх гэсэн хэлбэр байдаг.

Хууль бус үйлдлээр олсон орлого гэж юуг хэлэх вэ?

Хууль бус үйлдлээр олсон гэж татварын болон бусад хууль тогтоомжийг зөрчиж олсон орлогыг хэлнэ.

Татварын байцаагчид албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн гэдгийг тайлбарлаж өгнө үү?

Саад учруулсан гэж:

- Татварын байцаагч албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан, мэдээг гаргаж өгөхгүй байх
- Байр агуулахад нэвтрэн орох боломж олгохгүй байх
- Тооллого, тооцоог будлиантуулах
- Үзлэг шалгалт, ажлын зураг авалт хийлгэхгүй байх зэрэг санаатай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Эсэргүүцэл үзүүлсэн гэж:

- Татварын байцаагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цохих, өшиглөх, түлхэх
- Аливаа зүйлээр цацах,
- Биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэх
- Биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэхээр заналхийлэх
- Хэл амаар доромжлох зэрэг үйлдлийг хэлнэ.

Дундын суутгал гэж юуг хэлэх вэ?

Дундын суутгал гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас жилийн дундуур иргэдэд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах болон хуульд заасан бусад орлогод уг орлогыг олгож байгаа этгээд нь татварын хууль тогтоомжид заасны дагуу татварыг нь ногдуулан суутган авч төсөвт шилжүүлэхийг хэлнэ.

Татвар, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн гэж юуг хэлэх вэ?

Тухайн татвар төлөгч татвар, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн гэж:

- Хаягаа буруу тодорхойлсон
- Хаягийн өөрчлөлтөө татварын албанд мэдэгдэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгээгүй
- Нягтлан бодох бүртгэлийн болон тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсыг гаргаж өгөөгүй
- Татварын албанаас дуудсан үед хүндэтгэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй
- Шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаа нь мэдэгдэхгүй байх зэрэг шалтгаанаар ногдсон татвараа хуулийн хугацаанд төлөөгүй зэргийг хэлнэ.



Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуультай холбоотой асуулт, хариулт.

ТББ нь зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж байвал ААНБОАТатвар төлөх үү?

- ТББ-ууд нь дүрмийн бус (зорилгодоо нийцээгүй) үйл ажиллагаа явуулж болохгүй. Монгол улсын төрийн бус байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д: «Төрийн бус байгууллагыг дор дурдсан үндэслэлээр шүүх татан буулгана. 8.1.1. дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан» гэж заасан байдаг.
- Монгол улсын ААНБОАТатварын хуулийн 7-р зүйлийн 1-д: «Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө. 7.1.2. ТББ-ын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив. 7.1.7. нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого» гэж заасан байдаг тул эдгээрээс бусад орлогодоо ААНБОАТатварыг хуульд заасны дагуу ногдуулж төлнө.

ТББ зуучлалын үйл ажиллагаа явуулж болох уу?

Монгол улсын Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д: «Төрийн бус байгууллагын орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэж болно. 19.1. гишүүний татвар, хандив. 19.2. иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив. 19.3. дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого. 19.4. зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө» гэж заажээ. Эндээс харахад зөвхөн дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон зуучлалын үйл ажиллагааг явуулж болно. Хэрвээ дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулбал татан буулгах асуудал яригддаг.

ТББ нь санхүүгийн тайлангаа татварын байгууллагад ямар хуулийн дагуу хэдийд тайлагнах вэ? ААНБОАТатварын хуулийн дагуу улирал болгон уу, эсвэл ТББ-ын хуулийн дагуу жилд нэг удаа юу?

ТББ нь ААНБОАТатвар төлөгч мөн. Татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэж заасныг үндэслэн ААНБОАТ-ын хуульд заасны дагуу татварын тайлангаа улирлынхыг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийнхийг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор нутаг дэвсгэрийнхээ татварын албанд тушаана.

Гишүүддээ үйлчилдэг ТББ ямар татвар төлөх ёстой вэ?

Гишүүддээ үйлчилдэг ТББ нь ААНБОА татварын хуулийн 7 дугаар зүйлд: «7.1.2. Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив» гэж заасны дагуу гишүүд дэмжигчдийн татвар хандиваас бусад орлогодоо татварын багц хуульд заасан бүх төрлийн татварыг төлнө.

ТББ-ын удирдах зөвлөлөөс жил бүр тухайн оны төсвийг баталж, төсөвт зар сурталчилгаа, хэвлэл захиалга зэрэг зардлыг багтаасан. Төсөвт батлагдсан дээрх зардлуудыг албан татвар ногдох орлогоос хасч тооцох уу?

ААНБОА татварын хуулийн 5 дугаар зүйлд: «Зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг гүйцэтгэлээр нь тооцох боловч, тэдгээрийн нийлбэр нь тухайн аж ахуйн нэгж байгууллагын татвар ногдуулах орлогын 10 хувиас хэтэрч болохгүй», «... хэвлэл захиалга ...-ын зардлыг татвар ногдуулах орлогоос хасахгүй» гэж заасны дагуу төсөвт батлагдсан ч гэсэн хэвлэл захиалгын зардлыг татвар ногдуулах орлогоос хасч тооцохгүй. Төсөвт оруулж баталсан нь ассоциацийн удирдах зөвлөлөөс зарцуулах хөрөнгийн эрхийг баталж өгч байгаа хэрэг гэж ойлгож болно. Харин ТНО-ын 10 хувиас хэтрээгүй зар сурталчилгаа, сургалтын зардлыг ТНО-оос хасч тооцно.

ААНБОА татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг гүйцэтгэлээр нь тооцох боловч, тэдгээрийн нийлбэр нь тухайн аж ахуйн нэгж байгууллагын татвар ногдуулах орлогын 10 хувиас хэтэрч болохгүй гэсэн. Үүнийг тодорхой жишээгээр тайлбарлаж өгнө үү?

Тайлант хугацааны албан татвар ногдуулах орлогын 10 хувьтай тэнцэх хэмжээний зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлын дүнг татвар ногдох орлогоос хасна. Зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлын дүн нь тухайн хугацааны албан татвар ногдуулах орлогын 10 хувиас бага байх тохиолдолд гүйцэтгэлээр нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулна. Харин уг зардлын дүн албан татвар ногдуулах орлогын дүнгийн 10 хувиас дээш байвал 10 хувиас давсан хэсгийг татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулахгүй. Аж ахуйн нэгж байгууллага зар сурталчилгааны зардал, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулах тооцоог батлагдсан үзүүлэлт, маягтын дагуу гаргаж татварын тайланд заавал хавсаргана. Татвар ногдох орлогоос хасагдах зар сурталчилгаа, сургалтын зардлын хэмжээг дараахь аргаар тодорхойлно. Жишээ нь: «А» ТББ тухайн тайлангийн хугацаанд явуулсан үйл ажиллагаанаасаа 2.250.0 мянган төгрөгийн орлого олсон бөгөөд татварын хуулийн дагуу татвар ногдох орлогоос хасагдах зардлын нийт дүн 1.350.0 мянган төгрөг. Үүний дотор зар сурталчилгаа, ажиллагсдын сургалтын зардал 135.0 мянган төгрөг зарцуулжээ гэвэл:



А. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно:

ТНО - татвар ногдох орлого

ТНО* - татвар ногдуулах орлого

ХЗ - хасагдах зардал

$$\text{ТНО}^* = \text{ТНО} - \text{ХЗ} = 2.250.0 - 1.350.0 = 900.0$$

Б. Зар сурталчилгаа, сургалтын зардлын татвар ногдуулах орлогын дүнд эзлэх хувийг /ЗСЗ%/ гаргана:

ЗСЗ - зар сурталчилгаа, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлын гүйцэтгэл

$$\text{ЗСЗ} \% = \text{ЗСЗ} / \text{ТНО}^* \times 100\% = 135.0 / 900.0 \times 100\% = 15\%$$

В. Татвар ногдох орлогоос хасагдах зардалд орж тооцогдох зар сурталчилгааны зардлын хэмжээг /ЗСЗ*/ тодорхойлно:

$$\text{ЗСЗ}^* = \text{ТНО}^* \times 10\% = 900.0 \times 10\% = 90.0 \text{ мян төг}$$

Г. Зар сурталчилгаа, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлын хуулиар тогтоосон хязгаараас давсан хувь, хэмжээг тодорхойлно:

$$\text{Давсан} \% = \text{ЗСЗ}\% - 10\% = 15\% - 10\% = 5\%$$

$$\text{Давсан хэмжээ} = \text{ЗСЗ} - \text{ЗСЗ}^* = 135.0 - 90.0 = 45.0 \text{ мян.төг.}$$

Давсан хэмжээ болох 45.0 мянган төгрөгийн зар сурталчилгаа, ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулахгүй.

Д. «А» ТББ-ын татвар ногдуулах орлогоос хасагдах зардлын татварын тооцоололд оруулан тооцох хэмжээ:

$$1.350.0 - 45.0 = 1.305.0 \text{ мян.төг.}$$

Е. Албан татвар ногдуулах орлого:

$$2.250.0 - 1.305.0 = 945.0 \text{ мян төг болно.}$$

ААНОАТ-ын хуулийн заалтад заавал даатгуулах даатгалын хураамжийг албан татвар ногдуулах орлогоос хасна гэсэн өгүүлбэр бий. Заавал даатгуулах даатгалын хураамж нь НДШ-ийн хураамж уу? Энэ өгүүлбэрийг тайлбарлаж өгнө үү?

Даатгалыг заавал ба сайн дурын даатгал гэж ангилдаг. Улсын даатгалын хуулиар заавал даатгахар заагдсан даатгалын хураамжийг энэ заалтанд хамруулдаг юм. Үүнд: бүх төрлийн хариуцлагын даатгал гэх мэт орно. Жишээ нь: жолоочийн хариуцлагын даатгал.

Үйл ажиллагааны зорилгод нийцсэн бизнес эрхлэх гэдгийг тайлбарлана уу?

Төрийн бус байгууллагын дүрэмд заагдсан үйл ажиллагааг хэлнэ.

Хандивлагчдаас 1000\$ хандивлахад татвар ногдох орлогоос чөлөөлдөггүй, татвар төлөх болдог. Тэгэхээр том компаниуд ТББ-уудад хандив өргөхөөс зайлсхийдэг.

ААНБОА татварын хуулийн 7 дугаар зүйлд: «Албан татвар төлөгчийн дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө. 7.1.2. Төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив» гэж заасны дагуу дэмжигчдээс өгсөн хандив нь тухайн төрийн бус байгууллагын татвар ногдох орлогоос чөлөөлөгдөнө. Харин тухайн ТББ-ын үйл ажиллагааг дэмжигч компаний хувьд татварын дараах ашгаасаа зарцуулагддаг.

Тус байгууллага нь ашгийн бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага бөгөөд донор байгууллагууд манай үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ цалин болон бага хэмжээний урамшуулал олгох зөвшөөрөл өгдөг боловч үүнээс нь НДШ болон ХАОА татвар авахаар дургүйцдэг. Ер нь НДШ болон ХАОАТ, ААНБОА татвараас чөлөөлөх арга зам байгаа юу?

- Төслийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төрийн бус байгууллагын хувьд Монгол улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын болон татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөж болно. /Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан Монгол улсын олон улсын гэрээг хүчин төгөлдөр гэж үзнэ/ Энэ нөхцөлд ажил олгогчийн төлөх НДШ болон ААНБОА татвар, Монгол улсад түр оршин суугч татвар төлөгчид ХАОА татвар төлөхгүй.
- Харин төрийн бус байгууллага нь ажилтнуудад олгож байгаа цалин, хөдөлмөрийн хөлснөөс нь ногдох татварыг суутган авч төсөвт төлөх үүрэг хүлээдэг. Ер нь Монгол улсад байнга оршин суугч иргэд ХАОА татварын хуульд заасны дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж төлөх үүрэгтэй. Иргэдийн татвар төлөх үүрэг нь зөвхөн татварын хуульд төдийгүй үндсэн хуульд заагдсан байдаг юм.
- Түүнчлэн НД-ын санд шимтгэл төлснөөр өндөр наслах, өвчлөх, ажилгүй болох үед өөртөө, нас барах үед асрамжинд тань байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр төлөх агуулгатай нийгэм эдийн засгийн арга хэмжээ болох учраас өөрөө төлөх хэсгийгээ төлж байх нь ашигтай.

Хүн амын орлогын албан татварын хуультай холбоотой асуулт, хариулт

1. ТББ-д гадаадын иргэн ажиллавал ХАОА татварт хэдэн хувийг төлөх вэ?

- Гадаадын иргэн нь Монгол улсад 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа бол шаталсан хувиар, түр оршин суугч /183 хоногоос доош хугацаагаар/ бол 20 хувиар албан татвар ногдуулан тухайн ТББ суутган авч төсөвт шилжүүлнэ



Урлагийн чиглэлийн нэгэн ТББ нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд уран зургийн галерей ажиллуулдаг бөгөөд уран бүтээлчидтэй тодорхой хугацаатай гэрээ байгуулж, хамтран ажиллаж, тэдний зургийг өөрийн галерейгаар дамжуулан худалддаг юм. Зураачид зарагдсан зурагныхаа 25%-ийг тус ТББ-ын сан бүрдүүлэх ажиллагаанд хандивладаг. Худалдан авагчид нь голдуу гадаадын иргэд байдаг учраас төлбөрийг бэлнээр буюу бэлэн бусаар /картаар/ хийдэг учраас төлбөр нь манай дансанд шилждэг ба бид зураач, уран бүтээлчдэд өгөх 75%-ийг нь чекээр буцааж олгодог юм. Энэ тохиолдолд тухайн ТББ зураач, уран бүтээлчдэд өгч буй мөнгөнөөс татвар тооцох уу, эсвэл хувь хүн өөрөө хариуцах уу? Татвар тооцох бол ямар төрлийн татварыг хэдэн хувиар суутгаж авах вэ?

Энэ үйл ажиллагаа нь тус ТББ-ын дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа гэж ойлгож байна.

- Урлагийн бүтээл туурвиж байгаа зураач, уран бүтээлчдийн 5 сая хүртэлх төгрөгийн орлогод 5 хувиар; 5 саяас дээш төгрөгийн орлогод 10 хувиар татвар ногдуулан ногдох татварыг суутган авч 3 хоногийн дотор төсөвт төлнө.
- Зураач уран бүтээлчдийн орлогоос сан бүрдүүлэхэд төлж байгаа 25 хувийн орлого нь тухайн ТББ-ын орлого тул тайлант хугацааны татвар ногдуулах орлогыг тодорхойлж, шаталсан хувиар татвар ногдуулан төлнө.



Нэгэн ТББ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь өөрийн гишүүдийг мэдээллээр хангах гэсэн үйл ажиллагаа байдаг. Үүний дагуу олон улсын чуулга уулзалтыг зохион явуулсан. Энэ үеэр 7 хоногоос 1 сарын хугацаатай хурал зохион байгуулах ажилд хүмүүсийг авч ажиллуулсан. Энэ хүмүүст тавьж олгосон цалингаас ХАОАТатварын хуулийн 4.1.1б-д заасны дагуу 10 хувиар татвар ногдуулсан нь зөв үү? Хурал зохион байгуулахад оролцсон ажил үйлчилгээг ямар ажил үйлчилгээнд оруулах вэ?

- ХАОАТатварын хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасны дагуу дээрх орлогоос 10 хувиар албан татвар ногдуулж дундын суутгал хийх нь зөв. Гэхдээ орлого авагч нь татвар төлөгчийн дугаараа орлого олгогчид тэмдэглүүлээгүй бол 20 хувиар албан татвар ногдуулан суутган авч төсөвт шилжүүлнэ. Энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна.
- Хурал зохион байгуулах ажил үйлчилгээг гишүүддээ үйлчилдэг ТББ-ын үйлчилгээ гэж ойлгоно.

Жүжиг, дуурь орчуулсны хөлсөнд авсан орлогоос албан татварыг ямар журмаар авах вэ?

“Монгол улсын зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т «урьд туурвисан бүтээлийг ашиглан түүний үндсэн дээр бий болгосон үүсмэл бүтээл» гэж заасанд жүжиг, дуурийн орчуулга нь хамаарах тул албан татварыг Хүн амын орлогын албан татварын хуулийн 8 дугаар зүйлд зааснаар уг хөлс нь 5.000.0 сая төгрөг хүртэл 5 хувиар, 5.000.0 сая төгрөгнөөс дээш бол 10 хувиар ногдуулан суутгана.



Гэрээ түрээсээр 100.0 мянган төгрөгийн ажил хийлээ гэхэд 40 хувийг нь татварт авна гэдэг үнэн үү?

1997 оны 05 дугаар сарын 01-нээс нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байгаа Хүн амын орлогын албан татварын хуульд гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 40 хувиар татвар төлөхөөр заасан байв. Гэтэл энэ талаар иргэд, татвар төлөгчдөөс гаргасан санал, хүсэлтийг үндэслэн УИХ-аар уг асуудлыг хэлэлцэж, 1997 оны 6 дугаар сарын 25-наас эхлэн энэ орлогоос 10 хувиар татвар авахаар хуульд өөрчлөлт оруулсан. Иймд гэрээгээр ажил үүрэг, гүйцэтгэн цалин хөдөлмөрийн хөлс авагч нь 10 хувиар татвар төлөх бөгөөд энэ талаар орлого олгогчоор Иргэний орлого бүртгэх дэвтэрт тэмдэглүүлэн баталгаажуулж жилийн орлого татварын тооцоог Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар хийх ёстой.

Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын татварыг ногдуулахад тухайн хөрөнгийг ашигласан хугацаанаас хамаарах уу?

Хүн амын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 3 дугаар хэсгийн “а”-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгө худалдснаас олсон орлогын дүнд 2 хувиар татвар ногдуулахаар заасан тул уг хөрөнгийг хэдэн жил ашигласан нь татварын тооцоонд хамааралгүй.



Нэмэгдсэн өртгийн албан татварын хуультай холбоотой асуулт, хариулт

“Х” ТББ нь нийгэмд үйлчилдэг ТББ юм. Манай байгууллагад нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст зориулсан хувцас, эмчилгээний зүйл ирэхэд өндөр хэмжээний гаалийн татвар төлж аваад, тэдгээр зүйлийг үнэгүй тараадаг. Гаалийн татвар нь бидний үйлчилгээний зардал болдог, бид өөрсдийн үйл ажиллагааг /хурал, семинар, сургалт г.мэт/ санхүүжүүлэхийн тулд өөрийн байраа түрээслэдэг. Гэтэл байрны түрээсийн мөнгөнөөс НӨА татвар авах болоод байна.

- Тусламжийн барааг импортлох үед гааль, НӨА татвараас чөлөөлөгдөх бараа мөн эсэхийг тодруулах хэрэгтэй. Хэрэв НӨА татварын хуулийн 9 дүгээр зүйл, гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заагдсан гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа, тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл мөн бол татваргүй оруулж ирэх боломжтой.
- Аливаа аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлогын хэмжээ 10 сая төгрөгт хүрсэн өдрөөс эхлэн НӨА татвар төлөгчөөр бүртгүүлнэ. Харин ажлын байр түрээслэсний орлогыг НӨА татвараас чөлөөлөх тухай хуульд заагдаагүй тул түрээсийн төлбөрийн дүнд 15 хувиар НӨАТ ногдуулан түрээслэгчдээс нэхэмжлэн авч, худалдан авсан болон импортлосон бараанд төлсөн НӨАТ-ын хасалт хийх эрхтэй.



ТББ нь НӨА татвар төлөгч мөн үү? Мөн бол ТББ-д орж буй бүх орлогоос НӨА татвар тооцох уу? ТББ нь бусад байгууллагад төлсөн НӨА татварыг ямар замаар тооцоо хийж авах вэ?

- НӨА татварын хуулийн 4 дүгээр зүйлд: «... борлуулалтын орлогын хэмжээ 10 сая төгрөгт хүрсэн өдрийг НӨА татвар төлөгч болсон өдөр гэж үзнэ» гэснээс үзэхэд тухайн ТББ-ын борлуулалтын орлого 10 сая төгрөгт хүрсэн бол НӨАТ төлөгч мөн. Энэ өдрөөс эхлэн харьяалагдах татварын албанд хандаж татвар НӨА татвар төлөгчөөр бүртгүүлэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний татвар тооцох үнэлгээний 15 хувиар НӨА татварыг ногдуулан бусдаас нэхэмжлэн авах эрх үүснэ. Бусдаас нэхэмжлэн авсан НӨА татварын дүнгээс төсөвт болон бусад төлсөн НӨА татварыг хасч тооцон, НӨА татварын тайландаа тусгаж, дараа сарын 10-ны дотор харьяалах татварын албандаа гаргаж өгдөг. Эндээс харахад НӨА татвар төлөгч нь үйлчлүүлэгч, худалдан авагчдаас НӨА татварыг нэхэмжлэн авч, төсөвт дамжуулан төлж тооцоо хийх үүрэг хүлээдэг.

- Мөн хуулийн 11 дүгээр зүйлд «НӨА татвар төлөгчөөр бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд өөрийн үйл ажиллагаанд зориулан бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд болон өөрөө шууд импортлосон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн татвар/суудлын автомашин, түүний эд анги, хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ орохгүй/-ыг түүний төсөвт төлөх НӨА татвараас хасч тооцно. НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн аливаа этгээд борлуулсан бараа, ажил үйлчилгээндээ НӨАТ-ын падааныг заавал 3 хувь бичиж, эх хувийг НӨАТ-ын ногдуулалт төлөлтийг тодорхойлохтой холбогдсон баримтын бүрдэл болгон өөртөө хадгалж, үлдэх 2, 3 дугаар хувийг худалдан авагчид олгоно. Худалдан авагч борлуулагчаас авсан НӨАТ-ын падааны 2 дугаар хувийг тухайн сарын НӨАТ-ын тайланд хавсарган татварын албанд, 3-р хувийг өөрийн үйл ажиллагааны санхүүгийн баримт болгон хадгална. Хэрэв НӨАТ-ын падангүй бол НӨАТ-ын хасалт хийхгүй.

- Харин НӨА татвар төлөгч биш бол /импортлогчид хамаарахгүй/ бусдаас НӨА татварыг нэхэмжлэн авах болон хасалт хийх эрх үүсдэггүй тул бусад төлсөн НӨАТ-ыг зардалдаа оруулж тооцдог.

Хилээр орж ирж байгаа машинд онцгой татвар авчихаад, тэр татвар нэмсэн үнэн дээр гааль, НӨАТ авч байна. Энэ чинь татвараасаа татвар авч байгаа юм биш үү?

Импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг Монгол улсын гаалийн тарифын тухай хуульд зааснаар тодорхойлсон гаалийн үнэ дээр гаалийн албан татвар, онцгой албан татвар болон бусад татварыг нэмж тодорхойлно. Энэ нь татвараасаа татвар авч байгаа биш. Учир нь гаалийн болон онцгой албан татвар нь бүтээгдэхүүний өртөгт шингэдэг.

НӨАТ-ыг Аж ахуйн нэгж, байгууллага төлдөг үү? Энэ татварыг ард иргэдээс авч байна. Үүнийг үйлдвэрлэгч нь төлөх ёстой. Тайлбар өгнө үү?


Монгол улсын нутаг дэвсгэрт бараа импортлож байгаа, түүнчлэн үйлдвэрлэж борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар нь үйлдвэрлэгчээр дамжуулан хэрэглэгчээс авдаг хэрэглээний, шууд бус татварын төрөлд хамаарагддаг.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон өдөр гэж юуг хэлэх вэ? Манай байгууллага татварын албанд очиж бүртгүүлж гэрчилгээ авснаар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч боллоо гэж бодож байсан юм. Гэтэл гэрчилгээ авахаас өмнөх үеийн борлуулалтын орлогод НӨАТ ногдуулж, хүү торгууль тооцно гэнэ. Энэ зөв үү?

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон өдөр гэж нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа үйлдвэрлэж, ажил, үйлчилгээ үзүүлэн орлого олж байгаа иргэн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрсэн өдрийг хэлнэ. Та борлуулалтын орлогоо 10.0 сая төгрөгт хүрмэгц л НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх ёстой бөгөөд хэрвээ таны орлого 10.0 сая төгрөгт хүрсэн бөгөөд НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй нь татварын шалгалтаар нотлогдвол НӨАТ ногдох орлогын дүнгийн 8 хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлнө.

НӨАТ-ын хуулиар НӨАТ төлөгч болсон өдрийг борлуулалтын орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрсэн өдөр гэсэн мөртлөө НӨАТ төлөгч болсныг гэрчилгээ авснаар НӨАТ төлөгч болсон гэж үзэхээр хуулинд заасан байгаа юм. Энэ хоёр заалт чинь зөрчилдөөд байгаа юм биш үү. Нэгэнт л борлуулалтын орлого 10.0 сая төгрөгт хүрсэн л бол НӨАТ гэж үзэж бусдаас НӨАТ-ыг нэхэмжлэн авч төсөвт төлөх буюу бусдад төлсөн НӨАТ-ыг хасч өгч болдоггүй юм уу? Гэрчилгээ автал энэ хугацаанд татвар төлөгчид хохирч байна.

НӨАТ-ын хуулиар НӨАТ төлөгч болсон өдөр нь 10.0 сая төгрөгт хүрсэн өдөр боловч татвар ногдуулах хугацаа нь гэрчилгээ авсан өдрөөр тооцогдох учраас гэрчилгээ авч НӨАТ төлөгчөөр татварын албанд бүртгүүлэлгүйгээр бусдаас НӨАТ-ыг нэхэмжлэн авах боломжгүй. Иймээс борлуулалтын орлогоо 10.0 сая төгрөгт хүрмэгц л НӨАТ төлөгчөөр бүртгүүлж байх нь аливаа зөрчил гаргахгүй байхын үндэс юм.



ХТ бүлэг

**ТББ-ын
татварын
асуудлаар
мэдээлэл авах
эх сурвалжууд**





ТББ-ын татварын чиглэлээр гарч буй асуудлуудаар мэдээлэл авах эх сурвалжууд

1. “АСУУЛТ ХАРИУЛТЫН САН”

ҮТЕГ-аас 2002 онд баримтлах үндсэн чиглэлд заасан “Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх ажилд шинэчлэлт хийж, татварын алба, татвар төлөгчдийн хоорондын итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор ҮТЕГ-ын даргын 2002 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 111 дүгээр тушаалын дагуу “Асуулт, хариултын сан байгуулах, ашиглах журам” батлагджээ.

Энэ журмын хүрээнд Татварын удирдлага, арга зүйн хэлтэс, Татвар хураалтын хэлтэс, Сургалт үйлчилгээний төв, аймаг, нийслэл, дүүргийн татварын газруудад “Асуулт, хариултын сан” байгуулагдан ажиллаж байна.

Асуулт хариултын сангийн зорилго:

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа маргаантай асуудлуудыг цуглуулах, тэдгээрийг судалж хэлэлцэн нэг мөр болгож хариулт өгөх, аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын улсын байцаагч бүрт хүргэж судлуулах, татвар хураалт, хяналт шалгалтын арга зүйг боловсронгуй болгох, татвар төлөгчдийн асуултад өгч байгаа татварын байцаагчдын хариултыг нэгдмэл болгох, шаардлагатай асуудлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болгож байх зорилгоор “Асуулт, хариултын” санг байгуулдаг.

Асуулт хариултын сан нь:

- Татвар төлөгчдийн биеэр авчирч өгсөн, утсаар болон шуудангаар ирүүлсэн асуултууд
- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад татварын байцаагчдын дунд гарч буй эргэлзээтэй, ойлголт зөрүүтэй асуултууд
- Дээрх асуултуудад уг журамд заасны дагуу бэлтгэж гаргасан хариултуудаас бүрдэнэ.

Санг ашиглахад тавигдах шаардлага:

- “Асуулт хариултын сан”-г татварын төрөл тус бүрээр ангилан, санд байгаа асуулт хариултыг байцаагчид сайтар мэдэж, татвар төлөгчдөд хүргэнэ.
- Санд орж буй хариултууд нь ҮТЕГ-ын татварын удирдлага, арга зүйн хэлтэс, татварын хураалтын хэлтсүүдээр хянагдсан байна.



- Санг дараахь байдлаар ашиглаж, сурталчилгааны нэг хэрэгсэл болгоно. Үүнд:
- Сангийн асуулт хариултыг сэдэвчлэн үе үе, харин шинэ асуулт хариултыг тухай бүрд нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилж, нийтэд мэдээлнэ.
 - ҮТЕГ-аас гарсан шийдвэр, сангийн асуулт хариултыг компьютерийн сүлжээгээр дамжуулан байцаагчдад хүргэж, шинэ асуулт хариултын талаар тухай бүрд нь мэдээлэн, татварын байцаагч бүр нэг асуултад ижил хариулт өгдөг байна.
 - Санг ашиглах явцад татварын хуулиудад орж буй өөрчлөлтүүд, тэдгээртэй холбогдон гарсан аргачлал, журмыг сангийн баяжуулалтад тогтмол тусгана.
 - Татварын алба бүрт татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулж, иргэд татвар төлөгчдийн асуултад хариу өгдөг ажилтан бүхий сурталчилгааны өрөө тогтмол ажилладгийг мэдүүлж, уг өрөөг татвар төлөгчдийн ажил хэрэгч ярилцлага хийх болон татварын талаархи мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор байнга үйлчлүүлдэг байр болгоно.

Асуулт хариултын сангийн талаарх мэдээллийг татварын удирдлага, арга зүйн хэлтэс, татвар хураалтын хэлтэс, Сургалт үйлчилгээний төв, аймаг нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нараас авах боломжтой.

2. ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ НОМЫН САН

ҮТЕГ-ын даргын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар тушаалаар Татварын албанд ажиллагсад, оюутан сурагчид, татварын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж буй хүмүүст зориулж ҮТЕГ-ын дэргэдэх “Номын сангаас үйлчилгээ үзүүлэх түр журам”-ыг баталсан байна. Уг номын сан нь ҮТЕГ-ын Сургалт үйлчилгээний төв дээр ажилладаг.

Татварын албанд ажиллагсад, оюутан сурагчид, татварын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж буй хүмүүст татвар төлөх үүрэг, зохицуулалтын талаар мэдлэг олгох, тэднийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах зэрэг үйлчилгээ үзүүлэх таатай орчин бүрдүүлэхэд номын сангийн зорилго оршино.

Номын сангаар үйлчлүүлэх журам

- Номын сан нь ажлын 5 өдөр өглөө 10 цагаас оройн 16 цаг хүртэл /үдийн завсарлага 13.00-14.00/ ажиллана.



- Номын сангаар үйлчлүүлэгчид карт нээхэд 100 төгрөгийн төлбөр авах ба үйлчлүүлэгч нь иргэний үнэмлэх, ажлын газрын болон оюутны үнэмлэх, 1 хувь цээж зурагтай ирж карт нээлгүүлнэ.
- Татварын албаны ажилтнуудад шаардлагатай тохиолдолд /магистрын диплом бичих г.м./ 3-аас дээш хувьтай номыг гэрээр олгож болох ба ингэхдээ гэрээ байгуулах бөгөөд гэрээний хугацаа хэтэрвэл хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 200 төгрөгийн алданги тооцно. Номын сангийн фондод 1-2 хувь байгаа ховор номыг зөвхөн уншлагын танхимд ашиглуулна.
- Үйлчлүүлэгч номын сангийн номыг үрэгдүүлсэн тохиолдолд ховор буюу 3 хүртэлх хувьтай номыг зөвхөн номоор нь, хэрэв номыг буцааж өгөөгүй бол уг номын зах зээлийн үнийг 10 нугалж, олон хувьтай номыг хуучин тогтоосон үнийг нь тухайн үеийн зах зээлийн үнээр бодож дүнг 3-5 нугалж төлүүлнэ.
- Номын хуудас урсан, эрээчсэн тохиолдолд гэмтээсэн номыг ижил номоор төлүүлэх, төлөх боломжгүй тохиолдолд зохих төлбөрийг авна.
- Үйлчлүүлэгч уншлагын зааланд сууж ном уншихдаа ширээ, сандал дээр юм зурах, бичих, хог хаях, чимээ шуугиан гаргаж чанга ярихыг хориглоно.
- Үйлчлүүлэгч номноос хуулбар хийлгэвэл 1 хуудас нь 50 төгрөг байна.

3. ТАТВАРЫН АСУУДЛААР МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ (ХАЯГ, ХОЛБОО)

ҮТӨГ

№ Овог нэр	Албан тушаал	Ажлын утас
	ТАТВАРЫН УДИРДЛАГА, АРГА ЗҮЙН ХЭЛТЭС	
1. <u>Б.Эрдэнэбаатар</u>	хэлтсийн дарга	312493
2. Байцаагчид		311143, 311165
	ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС	
1. <u>Ч.Гансүх</u>	хэлтсийн дарга	321340
2. Байцаагчид		325712, 329515, 310893
	ТАТВАР ХУРААЛТЫН ХЭЛТЭС	
1. <u>Х.Хурметхан</u>	хэлтсийн дарга	311139
2. Байцаагчид		326388, 311165



УТЕГ-ын харьяа Төвлөрсөн төсөв орлого, хяналтын газар

ТАТВАР ХУРААЛТЫН ХЭЛТЭС		
1. Ш.Цэрэндорж	хэлтсийн дарга	311163
2. Байцаагчид		321172, 328791
ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ, МЭДЭЭЛЭЛ		
1. Д.Энхсайхан	хэлтсийн дарга	329551
2. Байцаагчид		327988, 321172
УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБА		
1. Я.Батцоож		328727
2. Ц.Цэрэндорж		328729
СУРГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ		
1. Я.Пүрвээ	дарга	321710
2. Байцаагчид, багш нар		324647, 321325


Нийслэлийн татварын газар

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС		
1. Аюушжав.Я	хэлтсийн дарга	313245
2. Байцаагчид		318759, 315309, 318891
ТАТВАР ХУРААЛТЫН ХЭЛТЭС		
1. Ганболд.Л	хэлтсийн дарга	311580
2. Байцаагчид		310671, 328220, 310577
<i>Төрийн захиргаа, удирдлагын тасаг</i>		
1. Энхбаяр.Д	сургалт сурталчилгаа	328220



Дүүргүүд

Овог нэр	Албан тушаал	Ажлын утас
	Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс	
<i>Готов.Д</i>	<i>хэлтсийн дарга</i>	311016
<i>Сайханчулуун.Д</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	311177
<i>Байцаагчид</i>		318066, 312728
	Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс	
<i>Лувсанцэрэн.Г</i>	<i>хэлтсийн дарга</i>	324840
<i>Оюунтуяа</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	310829
<i>Байцаагчид</i>		322112, 322203
	Баянгол дүүргийн татварын хэлтэс	
<i>Төмөрбаатар.Х</i>	<i>хэлтсийн дарга</i>	361645
<i>Уранчимэг</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	365606
<i>Байцаагчид</i>		363424, 368517
	Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс	
<i>Лхагважав.С</i>	<i>хэлтсийн дарга</i>	633217
<i>Эрдэнэбилэг.</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	633243
<i>Байцаагчид</i>		633249
	Баянзүрх дүүргийн татварын хэлтэс	
<i>Энхээ.Н</i>	<i>хэлтсийн дарга</i>	460943
<i>Цогзолмаа</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	452887
<i>Ариунгэрэл</i>	<i>байцаагч</i>	453416дууд
	Хан-Уул дүүргийн татварын хэлтэс	
<i>Занданбат.Д</i>	<i>хэлтсийн дарга</i>	341617
<i>Тунгалаг</i>	<i>хураалтын тасгийн дарга</i>	341959
<i>Байцаагчид</i>		341959
	Багануур дүүргийн татварын хэлтэс	
<i>Эрдэнэчимэг.Т</i>	<i>хэлтсийн дарга</i>	0121-21862
<i>байцаагчид</i>		0121-21389
	Налайх дүүргийн татварын хэлтэс	
<i>Умбаруу.Д</i>	<i>хэлтсийн дарга</i>	0123-22681
<i>Байцаагчид</i>		0123-22793



Хавсралт





Хавсралт 1. Нэр томъёоны тайлбар

А лбан татвар

Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ.

А лбан татвар төлөх үүрэг

Монгол Улсын Үндсэн хуульд “хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь иргэн бүрийн ёсчлон биелүүлэх үндсэн үүрэг мөн” гэж заасан.

А лбан татвар ногдох бусад орлого

Хандив, бэлэглэл, хууль тогтоомж, гэрээний дагуу бусдаас авсан хүү торгууль, нэхэмжлэгч нь тодроогүйгээс зохих байгууллагаас эзэмших эрхийг нь олгосон олз, тооллогоор илүүдсэн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үнэ зэргийг албан татвар ногдох бусад орлогод хамааруулдаг.

А ж ахуйн үйл ажиллагаа

Аливаа этгээд ашиг олох зорилготой буюу зорилгогүйгээр бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

А рилжааны банкны болон зээлийн үйл ажиллагааны орлого

Бусад этгээдэд төлбөрийн баталгаа гаргаж өгсний орлого, гадаад валют худалдсаны болон хадгалуулсны орлого, гадаад, дотоод төлбөр тооцоо хийсний шимтгэлийн орлого, Монгол банкнаас зөвшөөрөл авсан санхүүгийн буюу бусад ажил, үйлчилгээ эрхлэн явуулснаас олох орлого, зээлийн хүү, хугацаа хэтэрсэн зээлийн хүү, бусдаас авсан алданги, торгуулийн орлого зэрэг орлогууд хамаарна.

А шгийн төлөө байгууллага, сан

Аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоороо зардлаа бүрэн нөхөх зарчмаар ажиллах ёстой хуулийн этгээдийг хэлнэ.

А шиглагдаж байгаа байр

Орон сууцны зориулалтаар 1998 оны долдугаар сарын нэгнээс өмнө буюу хойно ашиглалтад оруулсан бөгөөд энэхүү хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар нэгэнтээ ногдуулсан барилгыг хэлнэ.

Бирж, брокерийн үйл ажиллагааны орлого

Эд хөрөнгө ба эд хөрөнгийг шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хамааруулна. Биржийн орлогод үнэт цаас хадгалах, үнэт цаасны арилжааны гүйлгээ эрхлэх, түүний төлбөр тооцоог хийх, арилжааны бус гүйлгээ явуулах, үнэт цаасыг бэлэглэх, өвлүүлэх, үнэ төлбөргүй шилжүүлэх, тендерийн саналын арилжаа явуулах, үнэт цаасыг нэр заан эзэмшүүлэх үйлчилгээ хийх болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааны орлого хамаарна.

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны орлого

Хууль буюу түүнд нийцсэн талууд хооронд бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн тодорхой эд хөрөнгө, эрхийг зээл, түүний хүүг төлж дуустал барьцаа болгон авч зээл олгох үйл ажиллагааг хэлнэ.

Банкнаас авсан хүүгийн орлого

Харилцах дансны тогтвортой үлдэгдэл болон сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө хадгалуулсны төлөө банкны байгууллагаас авч байгаа хүүгийн орлогыг үүнд хамааруулна.

Байнга оршин суугч татвар төлөгч

Монгол Улсад татварын жилийн аль ч үед хэвийн ажиллах байртай, татварын жилд эхэлсэн буюу дууссан аливаа 12 сарын хугацаанд 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа, гадаадад томилогдон оршин сууж байгаа Монгол Улсын иргэнийг хэлнэ.

Бараа

Мөнгөнөөс бусад бүх төрлийн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг хэлнэ.

Борлуулалт

Барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэхийг хэлнэ.

Гадаад улсын засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар авсан бараа

Давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас учирсан гарз, хохирлыг арилгахад зориулсан болон монгол улсын засгийн газраас гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан монгол улсын олон улсын гэрээний дагуу болон олон улсын буцалтгүй тусламжийн байгууллагын шугамаар хариу төлбөргүй илгээсэн барааг, буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагаас өгсөн санхүүжилтээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнүүд нэгэн адил хамаарна.

Гадаад валютын арилжаанаас олох орлого



Гадаад валютын арилжаа эрхлэх эрх бүхий татвар төлөгчийн энэ үйл ажиллагаанаас олж байгаа ханшны зөрүүгийн орлогыг хэлнэ.

Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага

Өөрийн гишүүдэд үйлчилдэг тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагыг хэлнэ. Жишээ нь: Зочид буудлуудын холбоо, Хувийн эздийн холбоо, г.м.

Даатгалын үйл ажиллагааны орлого

Бүх төрлийн даатгалын хураамж, давхар даатгалын байгууллагаас нөхүүлэн авсан хохирлын орлого хамаарах бөгөөд даатгалын байгууллагын бусад үйл ажиллагааны орлого хамаарагдана.

Дундын суутгал

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас жилийн дундуур иргэдэд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах болон хуульд заасны дагуу татварыг нь ногдуулан суутган авч төсөвт шилжүүлэхийг хэлнэ.

Зээллэгийн хүүгийн орлого

Бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого хамаарна. Улсын зээллэг, бусад үнэт зүйлсээс орох орлого болон тэдгээрийн борлуулалттай холбогдон үүсэх урамшууллын орлогоос, мөнгөн болон эд хөрөнгийн зээлийн үйл ажиллагаанаас олсон хүүгийн орлого орно.

Зуучлах үйл ажиллагааны орлого

Ашиг сонирхол бүхий этгээдүүдэд үйлчлэн тэднийг холбож өгсний болон аливаа үйл ажиллагааг бусдын нэрийн өмнөөс гүйцэтгэсний төлөө тэднээс авсан төлбөр (орлого)-ийг хэлнэ.

Иргэн

Монгол улсын иргэн, Монгол улсад зорчигч, Монгол улсын нутаг дэвсгэрт түр болон удаан хугацаагаар оршин суугч цагаач, гадаадын иргэн, оршин суугч бус гадаадын иргэн харьяалалгүй хүнийг хэлнэ.

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

Соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин аж ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг хэлнэ. Жишээ нь: мэргэжлийн холбоод.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон өдөр

Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа үйлдвэрлэж, ажил үйлчилгээ үзүүлсэн орлого олж байгаа иргэн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 10.0 сая төгрөгт хүрсэн өдрийг хэлнэ.

Орон нутгийн татвар

Улсын их хурлаас тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хувь, хэмжээг нь тогтоож тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварыг хэлнэ. Орон нутгийн татварт Бууны албан татвар, Нийслэл хотын албан татвар, Нохойны албан татвар, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, Улсын тэмдэгтийн хураамж, Ус, рашаан ашигласны албан татвар, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, Байгалийн ургамал ашигласны төлбөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Агнуурын нөөц ашигласны төлбөр, амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж, Газрын төлбөр, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хамааруулсан байна.

Оршин суугч бус татвар төлөгч

Байнга болон түр оршин суугчаас бусад татвар төлөгчийг хэлнэ.

Онцгой албан татвар төлөгч

Онцгой албан татвар ногдох бараа бүтээгдэхүүн импортолж, үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага албан татвар төлөгч байна. Жишээ нь: Бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхи, авто бензин, дизелийн түлш, суудлын автомашин

Саад учруулсан

Татварын албаны байцаагч албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэл болон тайлан тэнцэл, татварын тайлан мэдээг гаргаж өгөхгүй байх, байр агуулахад нэвтрэн орох боломж олгохгүй байх, тооллого тооцоог будлиантуулах, түүнчлэн үзлэг шалгалт, ажлын зураг авалтыг хийлгэхгүй байх зэрэг санаатай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Санхүүгийн хариуцлага

Татварын хууль тогтоомжийг татвар төлөгч зөрчсөний төлөө татварын албаны хүлээлгэдэг хариуцлага юм. Энэ нь үл маргах журмаар татвар, хүү, торгуулийг гаргуулах, нуун дарагдуулсан татвар ногдох зүйлийг гаргуулах зэрэг хэлбэрээр илэрнэ.

Татварын албаны үндсэн чиг үүрэг

Татварын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар аргачлал гаргах, сургалт сурталчилгаа явуулах, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал мөн.

Татварын субъект

Татварын субъект гэдэг нь тухайн төрлийн татварыг төлөх үүрэг хүлээсэн хуулийн этгээд эсхүл хувь хүнийг хэлнэ. Монгол Улсын татварын ерөнхий хуулийн тавдугаар зүйлд зааснаар хуулийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, тодорхой эрх бүхий, эсхүл эд хөрөнгө эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага татвар төлөгч байна.



- Монгол улсын иргэн
- Тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн
- Монгол улсад орлого олж байгаа оршин суугч бус этгээд
- Тус улсын нутаг дэвсгэрт байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, сан
- Тус улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар

T атварын объект

Татварын объект гэдэг нь татвар ногдуулах үндэслэл болох орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц зэрэг татвар төлөгчийн өмчлөлд буй татвар ногдуулах зүйлс юм.

T атвар төлөгч байгууллага

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татварын алба болон бүртгэх эрх бүхий бусад байгууллагад бүртгүүлсэн, энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар татвар төлөгч байгууллага гэж тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага, санг хэлнэ.

T атвар төлөгчийн үүрэг дуусгавар болох

Татвар төлөх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болно.

1. Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон.
2. Тухайн төрлийн татвар төлж дууссан. Энэ нь голдуу нэг удаагийн төлбөр, хураамж, татварт хамаарна.
3. Татвар төлөгч иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон.
4. Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан.

T атвар төлөгчийн хариуцлага

Татвар төлөгчийн хариуцлага гэдэг бол өөрийнхөө үйлдлийг хариуцах үүрэг шаардлагыг хэлнэ. Хууль зүйн хариуцлага нь иргэний эрх зүйн, захиргааны эрх зүйн, эрүүгийн эрх зүйн, сахилгын, санхүүгийн хариуцлагын хэлбэрээр илэрнэ.

T атварын эрх зүйн зөрчил

Орлогоо нуун дарагдуулах буюу бууруулах, татвар ногдуулах объектыг бүртгэлд үл тусгах, татвар ногдох зүйлийн бүртгэлийг тогтоогдсон журмыг ноцтойгоор зөрчиж хийх, татварыг цаг хугацаанд нь төлөхгүй байх, татварын тайлан мэдээг тогтоогдсон хугацаанд нь гаргаж өгөхгүй байх гэх мэт хэлбэрээр илэрнэ.

T атварын хөнгөлөлт

Тодорхой категорийн татвар төлөгч буюу татвар ногдох зүйлийг татвар төлөхөөс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх хуулиар тогтоогдсон санхүү-эдийн засгийн хэрэгслийг татварын хөнгөлөлт гэнэ.

Татвар төлөхөөс бүрэн чөлөөлөх

Татвар төлөгч хуульд заасан үндэслэлээр татвар ногдох ашгаа /зүйлээ/ бүрэн хэмжээгээр өөртөө үлдээж, өөрийн хүсэл зоригийн дагуу захиран зарцуулах эрхтэй гэсэн үг юм. Жишээ нь: Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд зааснаар жилийн борлуулалтын орлого нь 10 сая төгрөг хүрэхгүй байгаа бол энэ төрлийн татвар төлөхгүй байхаар заасан байдаг. Мөн аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд зааснаар төрийн бус байгууллагын дүрэмдээ заасан үйл ажиллагаанаас олсон орлогод албан татвар ногдуулахгүй.

Татвар төлөхөөс хэсэгчлэн чөлөөлөх

Татвар төлөгч хуульд заасан үндэслэлээр татвар ногдох зүйл /ашиг, орлого/-ээ багасгасан хэмжээгээр өөртөө үлдээж, өөрийн хүсэл зоригийн дагуу захиран зарцуулах эрхтэй гэсэн үг юм.

Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуух

Орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг биетээр нуун дарагдуулах, үндэслэлгүйгээр бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд тусгахгүй орхигдуулах, нягтлан бодох бүртгэл болон татварын тайланд санаатайгаар буруу бичилт хийх, хууль бус хэлцэл хийж, хууран мэхлэх, холбогдох баримт бичгийг гаргаж өгөхгүй байх, хуурамчаар өглөг үүсгэх, түүнчлэн баримт бичгийг татвар төлөхгүйн тулд хуурамчаар үйлдэх, аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэр, хөрөнгө, иргэний бичиг баримтаа бусдад ашиглуулах замаар татвараас зайлсхийх боломж олгосон зэрэг үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг санаатайгаар бууруулах

Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийн тоо хэмжээ, үнийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд санаатай багасган тусгах, орлогоо багасгаж харуулахын тулд засварлах замаар хуурамч баримт бичиг үйлдэх, зардлаа хуурамчаар өсгөх буюу орлогоо зохиомлоор багасгах үйлдлийг хэлнэ.

Татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийн тоо хэмжээг болгоомжгүйгээр бууруулах

Татвар ногдох орлого, татвар ногдох зүйлийн тоо хэмжээг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайлан мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсанд тусгахдаа тооны үйлдэл алдах, түүнчлэн нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтөлж, тайлан тэнцлээ зөв гаргасан боловч татвар ногдох орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүнг буруу тодорхойлсон үйлдлийг хэлнэ.

Татварын падаан



Борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, нэгжийн болон бүгд үнэ нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг тусгасан нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийг хэлнэ.

Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсноор татвар төлөх үүрэг дуусгавар болох

Улсын Их Хурал уг төрлийн татварын хуулийг хүчингүй болгож, татварын тооцоог хийж дуусгах хугацаа дууссан гэдгийг хэлнэ.

Татвар, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн

- Хаягаа буруу тодорхойлсон
- Хаягийн өөрчлөлтөө татварын албанд мэдэгдэж, улсын бүртгэлийн гэрчилгээндээ тэмдэглэл хийлгээгүй
- Нягтлан бодох бүртгэлийн болон тайлан тэнцэл, татварын тайлан, мэдээ, орлого, татвар тодорхойлох хуудсыг гаргаж өгөөгүй
- Татварын албанаас дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй
- Шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаа нь мэдэгдэхгүй байх зэрэг шалтгаанаар ногдох татвараа хуульд заасан хугацаанд төлөөгүй зэргийг хэлнэ.

Татварын хэмжээ

Татвар ногдуулах нэгжид ногдох татварын хэмжээг хэлнэ. Татварын хэмжээ нь татвар төлөгчийн орлогын тодорхой хувиар илэрхийлэгдсэн байвал татварын хувь хэмжээ гэдэг үгийг хэрэглэдэг.

Татвар ногдуулах нэгж

Татварын объектыг хэмжих нэгж юм. Орлогын албан татварт ногдуулах газрын нэгж болгон үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг хэрэглэдэг бол газрын татварт талбайг хэмжих гектор, акр гэх мэт нэгжүүдийг ашигладаг.

Татварын өр

Татварын хуулиар тогтоосон хугацаанд нь төлөгдөөгүй татвар, тэдгээрт ногдсон хүү, торгууль, татварын хяналт шалгалтаар илэрч төлөгдөхөөр тогтоогдсон нөхөн татвар, хүү, торгуулийг хэлнэ.

Татварын эрх зүй

Төрийн татварын тогтолцоо, татвар ногдуулах хураах журам, татварын хуулийн заалтыг зөрчсөний улмаас хүлээлгэх хариуцлагыг тогтоосон эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм.

Төлбөр

Төрийн өмч /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг/-ийг ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч, улс орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төлбөр гэнэ.

Төрийн бус байгууллага

Иргэд төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шууд эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага. Жишээ нь: Хамтын ажиллагааны нийгэмлэгүүд, Найрамдлын нийгэмлэгүүд.

Түр оршин суугч татвар төлөгч

Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос доош хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ.

Тэмдэгтийн хураамж

Төрийн зохих байгууллагаас үйлчилгээ үзүүлсний төлөө уг үйлчилгээг хүртэж байгаа этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Улсын татвар

Улсын Их Хурал, Засгийн газраас хувь хэмжээг тогтоосон бөгөөд манай улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх татварыг хэлнэ. Улсын татварт Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар, Гаалийн албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Онцгой албан татвар, Авто бензин дизелийн түлшний албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хамааруулдаг.

Үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний орлого

Борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний бүх орлого хамаарагдана.

Үл хөдлөх эд хөрөнгө

Газар, газраас салгамагц зориулалт, эдийн засгийн агуулгаа алдах олон наст ургамал, тарьц суулгац, ашигт малтмалын орд болон газраас салган хэрэглэж үл болох барилга, байгууламж, орон сууцны байшин зэрэг бодит болон хийсвэр аргаар хэмжиж болохуйц тодорхой хил хязгаартай эд хөрөнгө орно.

Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого

Үл хөдлөх эд хөрөнгөд газар түүнээс салгаж хэрэглэж үл болох зүйл хамаарах бөгөөд уг хөрөнгийг худалдан борлуулсны орлого үүнд хамаарна.

Үйлчилгээ

Бараа буюу мөнгө биш аливаа үйл ажиллагааг хэлнэ.

Хөдлөх хөрөнгө борлуулсны орлого

Үл хөдлөх эд хөрөнгөнөөс бусад үндсэн ба эргэлтийн бүх төрлийн хөрөнгө борлуулсны орлого хамаарна.

Хөрөнгө түрээслүүлсний орлого



Өөрийн өмчлөлд буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэндээ байгаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулсны төлөө авч буй төлбөрийг хэлнэ.

Хууль бус үйлдлээр олсон орлого

Татварын болон бусад хууль тогтоомжийг зөрчиж олсон орлогыг хэлнэ.

Хуулийн этгээд

Компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа эрхлэх аж ахуй, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн бус байгууллага, шашны байгууллага болон тэдгээртэй адилтгах бусад бүх байгууллагыг хэлнэ.

Хураамж

Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч, улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хураамж гэнэ.

Хууль бус үйлдлээр олсон орлого

Татварын хууль тогтоомжийг зөрчиж олсон орлогыг хэлнэ.

Хүн амын орлогын албан татвар төлөгч

Монгол Улсын иргэн, Монгол улсад оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүн, Монгол Улсад орлого олж байгаа тус улсад оршин суугч бус этгээд байна.

Хүчингүй гэрээ, хэлцэл

Утга агуулгаараа хууль зөрчсөн буюу хуулиас гадуур хийгдсэн, бага насны хүмүүс, сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио зэрэг шалтгааны улмаас эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдтэй хийсэн хэлцэл, айлган сүрдүүлэх буюу аргагүй гачигдлыг далимдуулан хийсэн хэлцэл, хууль ёсны үр дүн гаргахын тулд биш зөвхөн дүр үзүүлэн хийсэн хэлцлийг хэлнэ.

Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчдийн орлого

Хувьцаат компанийн хувьцааг эзэмшиж олсон орлогыг хувьцааны ногдол ашиг гэх бөгөөд өр нэхэмжлэхээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрхээс үүсэх орлого болон түүнтэй адилтгах орлогыг хувь хүртэгчдийн орлогод хамааруулна.

Хонжворт сугалаа, таавар, тоглоомын орлого

Бүх төрлийн төлбөрт тоглоом тоглуулах, видео болон аудио хуурцаг худалдах, түүний бичлэгийн хөлсний үйлчилгээ хийх, видео үзвэр болон хонжворт сугалаа, тааварт тоглоом зэргийн орлого үүнд хамаарна.

Ш илжүүлсэн орлого

Гэрээ хэлцлийн үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагад болон иргэний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар нь дамжуулан олгохоор бэлэн бусаар шилжүүлснийг хэлнэ.

Эрх эзэмших болон эрхийн шимтгэлийн орлого

Уран зохиол нийтлэх, урлаг, уран сайхны болон шинжлэх ухаан техникийн нээлт, бүтээл, патент, барааны тэмдэг, дизайн, загвар, зураг төсөл, нууц томъёолол буюу процессыг ашиглах, үйлдвэрлэл, худалдаа, шинжлэх ухааны багаж хэрэгсэл болон туршлагатай холбогдсон мэдээлэл зэрэг оюуны бүтээл эзэмших эрх эдлэхийг тодорхой эрх эзэмших гэх бөгөөд уг эрхийг эдлэгч эзэмшсэн эрхээ бусдад ашиглуулсны төлөө авч буй төлбөрийг эрхийн шимтгэлийн орлогод хамааруулна.

Эсэргүүцэл үзүүлсэн

Татварын албаны байцаагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цохих, өшиглөх, түлхэх, аливаа зүйлээр цацах, биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэх, биеийн хүчний эсэргүүцэл үзүүлэхээр заналхийлэх, хэл амаар доромжлох үйлдлийг хэлнэ.



Хавсралт 2. Татвар төлөгчийн бүртгэл ба татварын маягтууд

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ

Татвар төлөгчөөр бүртгүүлэх ТББ нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд “Татвар төлөгчийн бүртгэлийн маягт-Төсөвт болон төрийн бус байгууллага” маягт /Маягт-ТБ-02/-ыг 3 дугаар хавсралтын дагуу бүртгүүлж, “татвар төлөгчийн гэрчилгээ”-г хүлээн авна.

Татвар төлөгчийг бүртгэлд хамруулах үйл ажиллагаа нь тэдэнд татвар төлөгчийн дугаар олгохоос эхэлнэ. Татвар төлөгчийн дугаар /ТТД/ нь татварын албанаас татвар төлөгчийг таньж тодорхойлох зорилгоор ашиглагдаж буй код юм. ТТД нь татвар төлөгчдөд ямар төрлийн татвар төлөхөөс хамаарахгүйгээр зөвхөн нэг удаа олгогдох бөгөөд өөрчлөгдөхгүй байнгын дугаар байна.

Төсөвт байгууллага, олон нийтийн байгууллага, шашны байгууллага болон өмчлөгчдөөс санхүүждэг байгууллагуудын хувьд тэдгээрийг хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлд бүртгэх үед олгогдох улсын бүртгэлийн регистрийн дугаар нь татвар төлөгчийн дугаар болж ашиглагдана.

Төсөвт үйлдвэрийн газар, төрийн бус байгууллага /олон нийтийн байгууллага, сан, шашны байгууллага/, Гадаадын ААНБ-ын салбар төлөөлөгчийн газар, өмчлөгчөөс санхүүждэг бусад байгууллагуудын хувьд тэдгээрийн ажил үйлчилгээ эрхэлж буй нутаг дэвсгэрийн татварын албанд очиж татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Татвар төлөгчийн бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн зүйл, хөрөнгийн хэмжээ, нэр төрөл, эрхэлж буй ажил, үйлчилгээний чиглэл нь өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлт орсноос хойш нэг сарын дотор харьцагч татварын албанд /хариуцсан татвар хураалтын байцаагчид/ мэдэгдэж, ТБ-06 маягтыг хөтлөн бүртгэлдээ нэмэлт өөрчлөлтийг хийлгэнэ.

Татвар төлөгч дараах нөхцөлд татвар төлөгчийн бүртгэлээс хасагдана. Үүнд:

- Татвар төлөгч нас барсан, нас барсанд тооцогдсон
- Хуулийн этгээд татан буугдсан
- Хуулийн этгээд дампуурсан

Бүртгэлээс хасагдах тухай татвар төлөгчийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч татвар төлөгчийн бүртгэлээс хасахад шаардагдах баримт материалыг бүрдүүлж ахлах байцаагчид өгнө. Үүнд:

- Баримтын шалгалт хийсэн акт материал
- Татварын өрийг барагдуулсан санхүүгийн баримт



- Хаалтын тайлан тэнцэл

Хураалтын хэлтэс /тасаг/-ийн ахлах байцаагч ТБ-05 маягтыг хөтөлж, хэлтсийн даргаар хянуулан гарын үсэг зуруулан, баталгаажуулж улсын бүртгэлийн албаны хариуцсан байцаагчид өгч бүртгэлийн алба шалган улсын бүртгэлээс хассаны дараа харьяалж буй татварын алба хасалт хийнэ.

Дараахь тохиолдолд татвар төлөгчийг тухайн төрлийн татвар төлөгчийн бүртгэлээс хасна. Үүнд:

- Тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон
- Татвар төлөгч нь тухайн төрлийн татвараас бүрэн чөлөөлөгдсөн

“Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2002 оны 231 тоот тушаал”-аас:

14. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэн авч, татвар төлөгчийн хувийн хэрэг нээхдээ “Татвар төлөгчийн бүртгэл” ТБ-01, ТБ-02 маягтуудыг хөтөлж, дараахь зүйлийг нарийвчлан тодруулна. Үүнд:

- 14.1 Татвар төлөгчийн оноосон нэр
- 14.2 Татвар төлөгчийн хаяг, регистрийн дугаар
- 14.3 Утас, факсны дугаар, и-мэйлийн хаяг
- 14.4 Хариуцлагын хэлбэр
- 14.5 Эрхлэх үндсэн болон туслах үйл ажиллагааны чиглэл
- 14.6 Өмчийн хэлбэр
- 14.7 Салбар нэгжийн тоо, хаяг
- 14.8 Харилцагч банкны нэр
- 14.9 Төгрөгийн болон валютын харилцах дансны дугаар
- 14.10 Удирдлагын овог, нэр, хаяг
- 14.11 Үйл ажиллагаа явуулах хугацаа
- 14.12 Дүрмийн сангийн хэмжээ, түүний бүрдүүлэлт
- 14.13 Хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл
- 14.14 Татвар төлөгчийн ажлын байрны хаяг

16. Татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татварын төрлөөр ангилан бүртгэхдээ дараахь зарчмыг баримтлан холбогдох бүртгэлийг хөтлөн программын тусламжтайгаар бүртгэнэ:

- 16.1 Аж ахуйн нэгж, байгууллага нь “Татвар төлөгчийн мэдээллийн сан”-д бүртгэгдсэнээс хойш 3 сарын дараа орлогын албан татвар төлөгчөөр шууд бүртгэгдэнэ.
- 16.2 Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх өргөдлийн ТТБ-01 маягтыг бөглөж өгснөөр нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэнэ.
- 16.3 Иргэний орлого, татвар тодорхойлох хуудсаар татварын тооцоо хийх иргэдийг татвар төлөгчийн бүртгэлийн ТТБ-03 маягтын 11.3-д заасан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 16.4 Онцгой албан татвар төлөгчийг Онцгой албан татварын тэмдэг олгосноор



- болон татвар төлөгчийн бүртгэлийн ТТБ-01 маягтын 7-д заасан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 16.5 Автобензин, дизелийн түлшний татвар төлөгчийг Татвар төлөгчийн бүртгэлийн ТТБ-01 маягтын 7-д заасан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 16.6 Үл хөдлөх эд хөрөнгийн татвар төлөгчийг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн бүртгэлийн ХТТ-01 маягтыг үндэслэн бүртгэж, жил бүрийн 2 дугаар сард багтаан шинэчилж байна.
- 16.7 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөгчийг Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн ХТТ-03 маягтыг үндэслэн бүртгэж, жил бүр шинэчилж байна.
- 16.8 Бууны албан татвар төлөгчийг Бууны албан татвар төлөгчийн бүртгэлийн жагсаалт ГХТ-01 маягтыг үндэслэн бүртгэж, жил бүр шинэчилж байна.
- 16.9 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгчдийг Татвар төлөгчийн бүртгэлийн ТТБ-01 маягтын 7-д заасан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 16.10 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг төлөгчийг төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн төлөөлөгчөөс авсан мэдээллийг үндэслэн бүртгэнэ.
- 16.11 Дараахь төлбөр, хураамжийг төлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг тухайн төрлийн татвар төлөгчөөр тусгайлан бүртгэхгүй бөгөөд уг төлбөр, хураамжийг ногдуулан хураан авч, төсөвт шилжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг татвар төлөгчөөр бүртгэнэ. Үүнд:
- 16.11.1 Улсын тэмдэгтийн хураамж
- 16.11.2 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр
- 16.11.3 Рашаан, ус ашигласны төлбөр
- 16.11.4 Байгалийн ургамал ашигласны төлбөр
- 16.11.5 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
- 16.11.6 Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж
- 16.11.7 Газрын төлбөр
- 16.11.8 Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж
17. Татварын төрлөөр ангилагдан бүртгэгдсэн татвар төлөгчдийн бүртгэлийг ашиглах, баяжуулах
- 17.1 Тухайн тайлангийн хугацаанд, тухайн төрлийн татварын “тайлан ирүүлбэл зохих” болон “татвар төлбөл зохих” татвар төлөгчдийн тоог татварын төрлөөр ангилагдан бүртгэгдсэн татвар төлөгчдийн бүртгэлийг үндэслэн тодорхойлно.
- 17.2 Татварын газар, хэлтэс, тасгийн дарга нь тухайн тайлангийн хугацаанд, “татварын тайлан ирүүлбэл зохих” татвар төлөгчдийн бүртгэлийг мэдээллийн сангаас гаргуулан авч, түүнийг үндэслэн тэдгээр татвар төлөгчдөөс татварын тайлан авах үйл ажиллагааг энэ дүрмийн 42-д заасны дагуу хийж



- гүйцэтгэхэд хяналт тавина.
- 17.3 Татварын төрлөөр ангилагдан бүртгэгдээгүй болон огт бүртгэгдээгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн татварын тайлан ирүүлсэн тохиолдолд тэдгээрийг татвар төлөгчөөр бүртгэж авна.
18. Татвар төлөгчийн бүртгэлээс хасах үйл ажиллагаа.
- 18.1 Татвар төлөгчийн бүртгэлээс хасагдахаар татвар төлөгчийн гаргасан хүсэлтийг хүлээн авч, түүнийг татварын албаны эрх бүхий ажилтнууд зөвшөөрч, “Татвар төлөгчийн бүртгэлээс хасалтын карт” ТБ-05 маягтын 1 дүгээр хэсгийг бөглөсөн тохиолдолд уг татвар төлөгч нь мэдээллийн санд орсон бүх төрлийн татварын бүртгэлээс хасагдана.
- 18.2 Татвар төлөгчийг татварын төрлөөр ангилагдан бүртгэгдсэн бүртгэлийн аль нэг төрлийн татвар төлөгчийн бүртгэлээс хасах үйл ажиллагааг “Татвар төлөгчийн бүртгэлээс хасалтын карт” ТБ-05 маягтын 2 дугаар хэсгийн мэдээллийг үндэслэн гүйцэтгэх ба ингэснээр тухайн татвар төлөгчийн уг татварын тайлан гаргах, татварын тооцоо хийх үүрэг нь дуусгавар болно.
- 18.3 “Хөрөнгө шилжүүлсэн болон ашиглалтаас хассан тухай тодорхойлолт” ХТТ-06 маягтыг үндэслэн татвар төлөгчийг тухайн төрлийн хөрөнгийн татвар төлөгчийн бүртгэлээс хасна.
19. Аж ахуйн нэгж, байгууллагын дүрэмд заасан үндэслэлээр татан буугдсан, үйл ажиллагаагаа явуулаагүй, цаашид явуулах боломжгүй татвар төлөгчдийг татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах талаархи саналаа удирдлагадаа тавьж, УТЕГ-ын даргын 2001 оны 119 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу шийдвэрлүүлнэ.
20. Энэ дүрмийн 19 дүгээр заалтанд заасны дагуу бүртгэлээс хасагдсан татвар төлөгчийн талаархи мэдээллийг эдийн засагчид өгч, мэдээллийн баазад оруулна.
21. Татвар төлөгчөөр бүртгэгдсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрт татвар төлөгчийн хувийн хэрэг нээн хөтлөх бөгөөд түүнийг □ татвар төлөгчийн мэдээллийн санд бүртгэгдсэн баримт таних дугаар □-аар дугаарлана.
22. Татвар төлөгчийн хувийн хэрэгт дараахь баримтуудыг бүрдүүлж, хавсаргаж хадгална:
- 22.1. Татвар төлөгчийн бүртгэлийн маягт
- 22.2. Татвар төлөгчийн бүртгэлд орсон нэмэлт, өөрчлөлт
- 22.3. Татвар төлөгчийн ирүүлсэн бүх төрлийн татварын тайлангууд



- 22.4. Татварын ногдол, барагдуулалтын тооцооллын хүснэгт / тухай бүр мэдээллийн сангаас хэвлэж авна/
- 22.5. Татвар төлөлтийн карт /сар бүр мэдээллийн сангаас хэвлэж авна/.
- 22.6. Татварын хяналт шалгалтын карт
- 22.7. Татварын өрийн карт /улирал бүр мэдээллийн сангаас хэвлэж авна/
- 22.8. Татвар төлөгчдөд хүргүүлсэн мэдэгдэх хуудас /мэдээллийн сангаас хэвлэж авна/
- 22.9. Татвар төлөгчийн бүртгэлээс хасалтын карт
- 22.10. Татвар төлөгчид хүлээлгэсэн хариуцлагын тухай бичиг баримт
23. Татварын улсын байцаагч нь хариуцуулсан аж ахуйн нэгж, байгууллага иргэдийг бүртгэж, тэдэнд татвар төлөгчийн хувийн хэрэг нээхдээ тэдгээрийн өмчлөл, эзэмшилд байгаа татвар ногдох дараахь объектийн талаарх мэдээллийг авч, тэмдэглэнэ. Үүнд:
 - 23.1. Үл хөдлөх хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, үнэлгээ
 - 23.2. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, үнэлгээ
 - 23.3. Бууны нэр төрөл, тоо, калибрийн хэмжээ
24. Татварын улсын байцаагч нь ажлаас халагдах, удаан хугацааны сургалтад хамрагдах, сургуульд явах, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан ажлаас чөлөөлөгдөх, өөр ажилд шилжин ажиллахад өөрийн хариуцаж байсан татвар төлөгчдийн хувийн хэргийг татвар хураалтын хэлтэс, тасгийн дарга эсвэл ажлыг нь хүлээн авч буй татварын улсын байцаагчид албан ёсоор жагсаалтаар хүлээлгэн өгнө.
25. Тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөх татварын төрлүүдийг тогтоож, энэ талаар татвар төлөгчид танилцуулж, татварын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгнө.
26. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын хувийн хэргийг улсын бүртгэлд орсон өөрчлөлтийг ТБ-06 маягтаар гаргасан мэдээллийн дагуу баяжуулж, орсон өөрчлөлтийн хүрээнд уг аж ахуйн нэгж, байгууллагын төлөх татварын төрөлд өөрчлөлт орохоор байвал энэ талаар татвар төлөгчдөд мэдэгдэж, мэдээллийн баазад оруулна.
27. Татварын улсын байцаагч нь татвар төлөгчөөр шинээр бүртгүүлсэн болон татвар төлөгчийн бүртгэлдээ нэмэлт, өөрчлөлт оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн талаарх мэдээллийг ТБ-01, ТБ-02, ТБ-03, ТБ-05, ТБ-06 маягтаар эдийн засагчид өгч, мэдээллийн баазад оруулна.



Машгт ТТ- 11

Үндэсний татварын алба



Суутгаан тооцсон татварын тайлан- I

1. ТТД: [][][][][][][][][][]

2. Нэр: _____

3. Тайланг хуваацаа: он [][][][] улирал [][]

Зөвхөн татварын албан ажлын хэрэгцээд	
БТД:	[][][][][][][][][][][]
Татварын байцаагч:	[][][][][][][] Тэмдэг
Хүлээн авсан:	
Он, сар, өдөр: _____	

*(Тайлангийн үзүүлэлтүүдийг оны эхлээс өссөн дүнгээр болгоно)***1. Хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан шалны, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын дүн (мян. төг)**

а/ Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн дүн (мян.төг)

б/ Татвар ногдуулах орлогын дүн (1-1а) /мян.төг/

в/ Ногдуулсан татвар, бүгд / 16* шаталсан хувиар/ (мян.төг)

г/ Хуулийн дагуу үзүүлэх татварын нийт хөнгөлөлт, (мян.төг)

д/ Суутгавал зохих татвар / 1в □ 1г/ (мян.төг)

е/ Ажиллагсдын тоо, үүнээс татвар суутган тооцох орлогын шатлалаар

- 10 хувиар суутгуулан тооцогч

- 11 - 20 хүртэл хувиар суутгуулан тооцогч

- 21 - 40 хүртэл хувиар суутгуулан тооцогч

ё/ Татварын хөнгөлөлт үзүүлсний дараа татвараас бүрэн чөлөөлөгдсөн иргэдийн тоо

2. Гэрээгээр ажла, үүрэг гүйцэтгэсэн иргэдэд олгосон шалны, хөдөлмөрийн хөлс болон адилтгах орлогын дүн (мян. төг.) *(хадаргааг ТТ-11(2) маягтаар гаргаж)*

а/ Суутгавал зохих татвар (мян.төг)

3. Хувиараа бараа, материал түүхий эд худалдсан иргэдэд олгосон орлогын дүн (мян.төг.)*(хадаргааг ТТ-11(3) маягтаар гаргаж)*

а/ Суутгавал зохих татвар (мян.төг)

4. Тайлангийн хугацаанд суутгавал зохих татварын дүн 1д+2а+3а/**5. Урал тайлангийн эцсийн илүү /Кт/, дутуу /Дт/**

6. Суутган тооцож төсөвт шилжүүлсэн татварын дүн /Кт/

7. Тайлангийн эцсийн илүү /Кт/, дутуу /Дт/

8. Тайлан хожимдуулсны торгууль /Дт/

9. Төсөвт төлөх нийт төлбөрийн дүн /Дт/

Дүн/Тоо /

(мян.төг)

Дт Кт

Тайланг үзнэ зөв гаргасан:

Дарга /Захирал/

Ерөнхий нягтлан бодогч

Тайланг хинаж хүлээн авсан:

татварын улсын байцаагч

200 оны сарын өдөр

Жич: Ушрын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж харьцалгах татварын албад ирүүлж



ҮТЕГ-ын даргын 2002 оны 129 дугаар
тушмалын 10 дугаар хавсралт



Маяг ТТ-14

Үндэсний татварын алба

**Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан иргэний орлогын
албан татварын тайлан**

1. ТТД: [][][][][][][][][][][][][][][][]

2. Нэр: _____

3. Татвар төлөгчийн одоогийн хаяг :

[][][]	Аймаг, хот: _____	Утас1: _____	Утас 2: _____
[][][]	Сум, дүүрэг: _____	Факс : _____	
[][][]	Баг, хороо: _____	Шуудангийн хайрцаг No.: _____	
[][][][]	Гудамж, хороолол: _____	Е-мэй хаяг: _____	
[][][][]	Байшин: _____		
[][][][]	Хашаа, хаалга: _____		

Борлуулсан үл хөдлөх эд хөрөнгийн:

4. Нэр, төрөл: _____

5. Гэрчилгээний дугаар: _____ 6. Үнэлгээний дүн: _____

7. Борлуулсан огноо: ____ * ____ * ____

Үл хөдлөх эд хөрөнгө худалдаж авсан этгээдийн:

8. ТТД: [][][][][][][][][][][][][][][][]

9. Нэр: _____

10. Хаяг :

[][][]	Аймаг, хот: _____	Утас1: _____	Утас 2: _____
[][][]	Сум, дүүрэг: _____	Факс : _____	
[][][]	Баг, хороо: _____	Шуудангийн хайрцаг No.: _____	
[][][][]	Гудамж, хороолол: _____	Е-мэй хаяг: _____	
[][][][]	Байшин: _____		
[][][][]	Хашаа, хаалга: _____		

(мөнгөн төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Дүн
1. Үл хөдлөх эд хөрөнгө худалдаснаас олсон орлого	
2. Нөгдүүлсэн татвар (2%)	
3. Төлсөн татвар	
4. Дутуу төлсөн	

Тайланг үнэн зөв гаргасан:
Иргэн: / /

Тайланг хянаж хүлээн авсан:
Татварын улсын байцагч / /

20... оны ... сарын ... өдөр



Төрийн бус байгууллагын үйлдвэр

АТГА

**Ажлын үр дүн, байгууллагын үйлдвэр
хүндэтгэсэн үйлдвэр**

1. ҮҮД: _____ 2. Үйлдвэр: _____

3. Тархал хугацааны хугацаа: _____

4.1. Ажлын үр дүн: _____ Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

4.2. Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

4.3. Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

5. Ажлын үр дүн: _____ Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

6. Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

7. Үйлдвэр: _____ Үйлдвэр: _____

Төрөл	Хугацаа	Үйлдвэр	Үйлдвэр
1. Үйлдвэр	1	1	1
2. Үйлдвэр	2	2	2
3. Үйлдвэр	3	3	3
4. Үйлдвэр	4	4	4
5. Үйлдвэр	5	5	5
6. Үйлдвэр	6	6	6
7. Үйлдвэр	7	7	7
8. Үйлдвэр	8	8	8
9. Үйлдвэр	9	9	9
10. Үйлдвэр	10	10	10
11. Үйлдвэр	11	11	11
12. Үйлдвэр	12	12	12
13. Үйлдвэр	13	13	13
14. Үйлдвэр	14	14	14
15. Үйлдвэр	15	15	15
16. Үйлдвэр	16	16	16
17. Үйлдвэр	17	17	17
18. Үйлдвэр	18	18	18
19. Үйлдвэр	19	19	19
20. Үйлдвэр	20	20	20
21. Үйлдвэр	21	21	21
22. Үйлдвэр	22	22	22
23. Үйлдвэр	23	23	23
24. Үйлдвэр	24	24	24
25. Үйлдвэр	25	25	25
26. Үйлдвэр	26	26	26
27. Үйлдвэр	27	27	27
28. Үйлдвэр	28	28	28
29. Үйлдвэр	29	29	29
30. Үйлдвэр	30	30	30
31. Үйлдвэр	31	31	31
32. Үйлдвэр	32	32	32
33. Үйлдвэр	33	33	33
34. Үйлдвэр	34	34	34
35. Үйлдвэр	35	35	35
36. Үйлдвэр	36	36	36
37. Үйлдвэр	37	37	37
38. Үйлдвэр	38	38	38
39. Үйлдвэр	39	39	39
40. Үйлдвэр	40	40	40
41. Үйлдвэр	41	41	41
42. Үйлдвэр	42	42	42
43. Үйлдвэр	43	43	43
44. Үйлдвэр	44	44	44
45. Үйлдвэр	45	45	45
46. Үйлдвэр	46	46	46
47. Үйлдвэр	47	47	47
48. Үйлдвэр	48	48	48
49. Үйлдвэр	49	49	49
50. Үйлдвэр	50	50	50



	Баяны зээлийн эрсдлийн санд төвлөрүүлсэн хөрөнгө	44	
	Зар сурталчлалтаа, ажиллагаагийн сургалт, давтан сургалтын зардал	45	
	Хуралдаж берүүлсэн хувьцааг худалдаж авсан үнэ	46	
	Хуралдаж берүүлсэн хөдлөх хөрөнгийн үлдэгдэл өртөг	47	
	Даатгалын байгууллагын тухайн жилд байгуулсан нөөцийн сан	48	
	Татвар ногдох орлогоос хаасагдах бусад зардлууд	49	
	5. Татвар ногдуулах орлогын зарцуулга (мөр 51+52+... + 59)	50	
Үүрэг	Зар сурталчлалтаа, ажиллагаагийн сургалт, давтан сургалтын зардалын титвар ногдуулах орлогын 10 хувьас хэтэрсэн дүн	51	
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүү	52	
	Хөрөнгө эзэмшигчдэд тогтоосон хязгаарны зардалын хэтэрсэн дүн	53	
	Их засварын зардал	54	
	Бүх төрлийн торгууль ба татвар төлөгчийн буруугаас бусад учруулсан хохирлыг өндхөн төлөөс	55	
	Сайн дурын даатгалын хураамж	56	
	Бараа, материалын хэвийн хоргогдол	57	
	Бүх төрлийн шагнал, урамшуулал, тэтгэмж, бусад өгсөн хандиа, бэлэг дурсгал, хүлээн авалт, хэвлэл захиалгын зардал	58	
	Харилцан хамарал бүхий хуулийн этгээдэд өгсөн эзэл бэлэн хүү тооцогдох өр тасбирийн дүн (Эзэлдүгэлчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгийн 30-аас дээш хувьд ногдох)	59	
	6. Татвар ногдуулах орлогын дүн (мөр 1-15 -22+50)	60	
	7. Ногдуулсан татвар	61	
8. Чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх татварын дүн (мөр 63+64+... + 72)	62		
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	63	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	64	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	65	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	66	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	67	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дэх хэсгийн дагуу	68	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	69	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дэх хэсгийн дагуу	70	
	ААНБОАТ-ын хуулийн Таугаар зүйлийн ... дах хэсгийн дагуу	71	
	72	
	9. Төлбөл зохих татвар (мөр 61- 62)	73	
	10. Бүх төрлийн төлбөрт төлсөн, видео, аудио хууриаг, гүүний бичлэгийн хэсгийн үйлчилгээ, видео үнээр, хонжворт сүлээн, таагарын орлогод ногдуулсан татвар (78* 40%)	74	
Үүрэг	1. Орлогын дүн	75	
	2. Баримтаар нотлогдох зардал	76	
	3. Хонжворт өгсөн мөнгө бэлэх барааны үнэ	77	
	4. Татвар ногдуулах орлого (мөр 75- 76- 77)	78	
	11. Үл хэдлэх эц хөрөнгө борлуулсаны орлогод ногдуулсан татвар (мөр 80*2%)	79	
	Үл хэдлэх эц хөрөнгө борлуулсаны орлого	80	
	12. Гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газрын өөрт ногдох анхны анхны талварил шилжүүлсэн ашиг, орлогод ногдуулсан татвар (мөр 82*20 %)	81	
	Гадаадад шилжүүлсэн ашиг, орлогын дүн	82	
	13. Нийт төлбөл зохих татварын дүн (мөр 73+74+79+81)	83	

Тайланг үзэн зөв гаргасан: _____ Тайланг хянаж хүлээн авсан: _____
 Дарга /Замралт/ татварын үлсэм байшагч:

Ерөнхий нягтлагч бодогч:
 20 ... оны ... сарын өдөр

ТТД - Татвар төлөгчийн дугаар



Ашигласан материал

1. “Татвар” эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, ХЗДХЯ, ХЗҮТ, ҮТЕГ, 2003, 2004 он
2. Татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагад тусламж, ҮТЕГ, УБ хот, 2003 он
3. Татвар төлөгч иргэдэд тусламж, ҮТЕГ, УБ хот, 2003 он
4. Налогообложение некоммерческих организаций, ICNL, 2002 г.
5. Татварын тогтолцоо, эмхэтгэл, 1, 2 дугаар дэвтэр, Б.Ганхүлэг, 2002 он
6. Татвар, нягтлан бодох бүртгэл, Монгол-Японы татварын бүртгэлийн судалгааны «Кайкэй» нийгэмлэг, 2004 он
7. Татварын бүртгэл, хяналт шалгалт, Г.Алтанзаяа, Д.Баяраа, С.Мятавжанцан. 2002 он
8. Татварын хуулийн эмхэтгэлүүд, 1-5 дугаар дэвтэр, 2002 он
9. Төрийн мэдээллийн сэтгүүлүүд, 2000-2003 он
10. Гуреев.М. Налоговое право. 1998 он Москва
11. Петрова Г.В. Налоговое право. 2000 он Москва
12. Налогообложение не комерческих организаций ICNL 2002г
13. Japanese Taxation
14. Татварын эрх зүй, Д.Дүгэржав, М.Гомбосүрэн, 2003 он
15. Төрийн санхүүгийн удирдлага, Л.Энхбаяр, Л.Отгонтуяа, 2002 он
16. Зах зээлийн эдийн засгийн онол, практик үндэс, Г.Миеэгомбо, Б.Сувд, 1997 он
17. Төсвийн орлого, зарлага санхүү ба ХАЕТ-ийн үр ашигтай ашиглалт. Монгол-Японы хамтарсан симпозиумын илтгэл, Фужимото.А.
18. Монгол улсын зах зээлийн эдийн засгийн шилжилт хөгжлийн судалгаа, санхүү төсвийн судалгааны хүрээлэн. 2003 он
19. Black’s Law dictionary
20. Анализ и оценка состояния бизнеса, Панкою В.В, 2004 он
21. Бухгалтерский учёт и налогообложение, Чайковская Л.А, 2004 он Москва



“ТББ ба татвар” гарын
авлагатай холбогдон гарах
асуулт, лавлах зүйл болон
бусад мэдээллийг Ардчиллын
Боловсрол Төв болон
Нийслэлийн Татварын
Газраас дараахь хаягаар
хандаж авна уу.

Хаяг:**Ардчиллын Боловсрол Төв**

Шуудангийн хаяг: Төв шуудан,
УБ-13, ш/х-308
Утас/факс: 310560

И-мэйл: demo@magicnet.mn
<http://www.demo.org.mn>

Нийслэлийн Татварын Газар

Шуудангийн хаяг: УБ, Бага тойруу,
46-р салбар
Утас/факс: 313245, 318759